



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ГАРЫН АВЛАГА

КОМПЬЮТЕРИЙН ХЭРЭГЛЭЭ

ТӨСЛИЙН НЭР:	ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ИРГЭДЭД МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ МЭДЛЭГ ОЛГОХ- ХААГ-2015/Э010
ЗАХИАЛАГЧ:	МТШХХГ, БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН
ГҮЙЦЭТГЭГЧ:	ШУТИС, МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

УЛААНБААТАР ХОТ 2015



Монгол Улсын иргэдийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн Технологи, Шуудан Харилцаа Холбооны Газрын Бүх Нийтийн Үйлчилгээний Үүргийн Сангийн захиалгаар бүтээв.

зохиогчид: А.Алтангэрэл (Дэд профессор, Доктор Ph.D) Б.Золзаяа Э.Батцэцэг

РЕДАКТОР:

Б.Сүхбат (Дэд профессор, Доктор Ph.D) Б.Энхтөгс

Энэхүү гарын авлага нь олон нийтэд үнэгүй тараагдах буюу интернэтэд нээлттэй байршина. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх болон бусад хэлбэрээр ашиглах бол эх сурвалжийг заавал дурдана. Худалдахыг хориглоно.

УЛААНБААТАР ХОТ 2015

Өмнөх үг

Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газрын Бүх Нийтийн Үйлчилгээний Үүргийн Сан нь харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг тухайн хүн амын байршил, амьжиргааны түвшинг үл хамааран хүргэх, алслагдсан орон нутагт зайлшгүй шаардлагатай мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүргэх боломжийг бүрдүүлэх, сүлжээг барьж байгуулахыг эрхэм зорилго болгон 2015 оны байдлаар 260 гаруй сум, суурин газарт төсөл хөтөлбөрүүдийг хүргэн ажиллаж байна.

Сангийн санхүүжилтээр Монгол улсын хэмжээнд нийт 74 сум, суурин газруудад Үүрэн холбооны үйлчилгээ, гар утас болон интернэтийн тухай 20 мянган ширхэг сургалтын материал, гарын авлагыг бэлтгэн хөдөө орон нутгийн иргэдэд хүргүүлэх, бүх сум, багт шуудангийн салбарын үйл ажиллагааг идэвхжүүлэх, 13 аймгийн 24 сумдад 25 метрийн өндөртэй цамхаг, 6 аймгийн 7 сумдад харилцаа холбооны хээрийн сайт, 118 сумдад интернэтийн үйлчилгээ зэрэг олон төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсээр байна.

Монгол Улсад интернэтийн үйлчилгээ нэвтэрч эхэлсэн 1996 оноос хойш өнөөдрийн байдлаар 20 орчим компани интернэтийн үйлчилгээ эрхэлж 80 гаруй хувь нь шилэн кабель, 3G, EVDO, GPRS, WIMAX ашиглаж байна. Үүнээс хөдөөгийн ард иргэдэд хамгийн тохиромжтой нь хөдөлгөөнт модемыг ашиглан тухайн сүлжээ орсон газраасаа интернэтэд холбогдох боломж юм.

Түүнчлэн орчин цагийн хүний амьдралын чухал хэрэглэгдэхүүн болсон компьютер, интернэтийн орчинд ажиллаж сурах, тоон телевизийн тухай ойлголт зэргийг багтаасан гарын авлага танд хүрч байна.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗАР БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

ГАРЧИГ

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ	1
МХХТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ	1
КОМПЬЮТЕРИЙН ХЭРЭГЛЭЭ	3
КОМПЬЮТЕРИЙН ТЕХНИК ХАНГАМЖ WINDOWS 7 ҮЙЛДЛИЙН СИСТЕМ. Цонхтой ажиллах Start товч Windows 7 Desktop Дэлгэцийн тохиргоо. Файлын зохион байгуулалт. Дотоод сүлжээ /LAN/ Файл шахах/задлах Вирусны эсрэг програм. Хэвлэх төхөөрөмж ашиглах.	
ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ	
ИНТЕРНЭТ ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД ИНТЕРНЭТИЙН ХУРД ДЭЛХИЙ ДАХИНЫ СҮЛЖЭЭ - WORLD WIDE WEB (WWW) ВЭБ САЙТ URL (UNIFORM RESOURCE LOCATOR) ХАЯГ	35 37 38 38 38 39
ВЭБ ХӨТӨЧ	40
GOOGLE CHROME ИНТЕРНЭТЭЭС МЭДЭЭЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ	40 46
ШУУД ХАЯГААР НЬ ХАНДАН МЭДЭЭЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ	
ХАИЛТЫН СИСТЕМ АШИГЛАН МЭДЭЭЛЭЛ, ҮИЛЧИЛГЭЭ АВАХ Түлхүүр үг, өгүүлбэрийн хэрэглээ	
ЭЛЕКТРОН ШУУДАН	
GMAIL ЭЛЕКТРОН ШУУДАН БОЛОН ТҮҮНИЙ БОЛОМЖУУД Gmail электрон шуудан Google+	59 59 60
Google Talk Google Docs Google Drive	60 60
Google Translate Google Scholar Google Books	62 62 62

НИЙГМИЙН СҮЛЖЭЭ	63
FACEBOOK ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ	63
TWITTER ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ	64
МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	65
МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ	65
МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХАЛДАХ ХАЛДЛАГЫН ТӨРЛҮҮД	66
МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ	67
ХЭРЭГЛЭЭНИЙ ПРОГРАМ	69
MICROSOFT WORD 2010	70
ДЭЛГЭЦИЙН АГШИНГ АВАХ /SCREENSHOT/	70
БАРИМТЫГ ХЭСГҮҮДЭД ХУВААХ	
Баримтыг хэсгүүдэд хуваах	71
Үүссэн хуваалтыг устгах	72
Тухайн хэсэг дэх текстийг босоо тэнхлэгийн дагуу зэрэгцуулэлт хийх	72
ХӨЛ БОЛОН ТОЛГОЙН МЭДЭЭЛЭЛ	73
Хэсгүүдэд хөл болон толгойн мэдээллийг ялгаатай хэрэгжүүлэх	73
ХҮСНЭГТТЭЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН ЗӨВЛӨГӨӨ	74
Хүснэгтийн гарчгийн мөрийг хүүдас бүрт давтах	74
Хуудас дамжин хүснэгтийн мөр хуваагдсан байдлыг удирдах	74
Багана дахь өгөгдлийг эрэмбэлэх	75
Текстийг хүснэгт болгон хөрвүүлэх	76
Хүснэгтийг текст болгон хөрвүүлэх	77
БАГАНА	78
Баримтад багана хэлбэрийг хэрэгжүүлэх	78
Багана таслах	79
ГАРЧИГ ҮҮСГЭХ	80
Обьектод гарчиг оруулах (Зураг, хүснэгт)	80
Зураг, хүснэгтийн жагсаалт автоматаар үүсгэх	
Гарчгийн жагсаалт автоматаар үүсгэх	83
ТАБ ЗОГСОЛТ	83
НЭМЭЛТ ТАЙЛБАР	85
Хуудасны төгсгөлд тайлбар нэмэх /Footnote/	85
Баримтын төгсгөлд тайлбар нэмэх /Endnote/	
Footnote болон Endnote хооронд хөрвүүлэлт хийх	
ТЭМДЭГЛЭЛ /BOOKMARK & CROSS REFERENCE/	
ӨӨРЧЛӨЛТИЙГ ХЯНАХ	89
Баримтад хийгдсэн өөрчлөлтийг хэрэгжүүлэх эсвэл татгалзах	90
ТАЙЛБАР	90
Тайлбар нэмэх	90
Тайлбарыг харуулах болон нуух	91
БАРИМТЫГ ХАРЬЦУУЛАХ	91
БАРИМТЫГ НЭГТГЭХ	92
МАЯГТ ҮҮСГЭХ	92
БАРИМТЫГ ХАМГААЛАХ	96

Баримтыг нээх үед асуух нууц үг	96
Нууц үгийг устгах	96
Баримтыг өөрчлөх үед асуух нууц үг	97
Нууц үгийг устгах	98
MICROSOFT EXCEL 2010	99
ХЭВЛЭХ	99
Хэвлэх үед хуудас бүр дээр гарчгийг харуулах	99
Excel програмын мөр, баганын гарчгийг хэвлэж харах	100
ЕХСЕL ФАЙЛУУДЫГ ЗЭРЭГЦҮҮЛЭН ХАРАХ	101
ФУНКЦ БОЛОН ТОМЪЁО	101
ЛОГИК ФУНКЦҮҮД	102
IF функц	102
АND функц	102
ОR функц	103
МАТЕМАТИКИЙН ФУНКЦҮҮД	103
SUMIF() функц	103
СТАТИСТИКИЙН ФУНКЦҮҮД	104
СОUNT функц	104
СОUNTА функц	105
COUNTIF функц	105
RANК функц	106
ТЕКСТИИН ФУНКЦҮҮД	108
LEFT функц	108
RIGHT функц	109
МІD функц	109
I RIM функц	109
	110
АЖЛЫН ХУУДАСНУУДЫГ УДИРДАХ	110
Баримт хооронд ажлын хуудаснуудыг хуулах оолон зөөх	110
Цонх хуваах	112
Мөр нуух	۲۲۲
	1 1 J
АЖЛЫН ХУУДСЫГ НУУХ	1 1 3
	1 14
Пэмэх, хасах, үржих, хуваах үйлдлүүд	115
transpose' couront	115
	117
Pivot table уусгах болон тууний хараглаа	117
Ріуот table дах егеглийг эрэмбалах болон шууж харах	177
Pivot Table дах огогдимг арамоолох оолог шүүх харах Pivot Table дах өгөгдлүүдийг автоматаар бүлэглэх, бүлгийн нэрийг өөрчлөх	122
Pivot Table дах огогдлуудийг автомат бүс аргаар бүлэглэх, бүлгийн нэрийг өөрчлө	122 ax 124
ХҮСНЭГТИЙН ЛЭЛ ХЭСЭГ	125
Дэд хэсгүүдийн нйилбэр олох	125
Дэд хэсгүүдийг хүраах болон задлах	126
Дэд хэсгүүдийн нийлбэрийг устгах	127
e e e e e e e e e e e e e e e e e e e	

MICROSOFT POWER POINT 2010	
МАСТЕР СЛАЙД	128
Мастер слайд үүсгэх	
Мастер слайдыг засах	
Мастер слайдуудыг хэрэглэх	
ОГНОО БОЛОН ХУУДАСНЫ ДУГААР	
ЗАГВАР	
Бэлэн загваруудыг ашиглах	
Бэлэн загварыг өөрчлөх	
Загварыг анхдагч байдлаар тохируулах	
Загварыг устгах	
АНИМЭЙШН	
Анимэйшн эффектүүдийг хэрэгжүүлэх	
Анимэйшнийг идэвхжүүлэх /Animation triggers/	
Анимэйшн хуулагч /Animation Painter/	
Анимэйшний тохируулга	
ҮЙЛДЭЛ ХИЙГДЭХ БОЛОМЖТОЙ ТОВЧНУУД /ACTION BUTTONS/	
Слайд руу шилжих	
Тодорхойлогдсон слайд руу шилжих	
URL холбогдох	
СЛАЙД ХАРУУЛАХ	
Слайдуудаар багц үүсгэх, ажиллуулах	
Слайдуудын багцыг засах	
НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР	
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ

Өнөө үед Мэдээлэл, Харилцаа Холбооны Технологи (МХХТ) нь төр, нийгэм, эдийн засаг, банк санхүү, боловсрол, эрүүл мэнд, худалдаа арилжаа гээд хүн төрөлхтөний аж амьдралын бүхий л салбарт эрчимтэй нэвтэрч, хөгжлийн гол хүчин зүйл болж байна. МХХТ нь үйлчилгээг ард иргэдэд илүү нээлттэй, тэгш хүртээмжтэйгээр хүргэх, мэдээлэл хуваалцах боломжийг сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, эргэх холбоо үүсгэх, аливаа үйл ажиллагаанд хяналт-шинжилгээг хийх зэрэгт үр дүнтэйгээр ашиглагдах болжээ. Энэ ч утгаараа сүүлийн жилүүдэд компьютер болон интернэтийг үр өгөөжтэй ашиглаж, МХХТ-ийн дэвшлийг сайтар ойлгон, амьдралд түлхүү хэрэгжүүлэх шаардлага тавигдсаар байна.

МХХТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

МХХТ-ийн тодорхойлолт нь хэрэглэж буй нөхцөл байдлаасаа хамааран олон янз байдаг. НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөрөөс гаргасан тодорхойлолтоор:

МХХТ нь мэдээлэлтэй харилцах аргачлал буюу мэдээллийг үүсгэх, хадгалах, түгээх болон солилцох зорилгоор ашиглагддаг бүтээгдэхүүн, хэрэглээ болон үйлчилгээний цогц юм. Тэдгээрийн тоонд "Уламжлалт буюу аналог" МХХТ болох радио, телевиз, утас болон "Шинэ буюу тоон" МХХТ болох компьютер, хиймэл дагуул, интернэт зэрэг багтана. Эдгээр хоёр ерөнхий ангилалд багтах аргачлалууд нь хослон ажиллаж бидний "сүлжээт ертөнц", харилцан холбоо бүхий утасны үйлчилгээний дэд бүтэц, стандартчилагдсан компьютерийн техник хангамж, интернэт, радио болон телевиз зэргийг бий болгон дэлхийн өнцөг булан бүрт хүрч байдаг юм.¹

Улс орны хөгжлийн төлөө аналог болон тоон МХХТ-ийн аль алиныг ашиглах нь чухал ч судалгаагаанаас үзвэл энэ хоёр технологи нь ихээхэн ялгаатай байгааг харуулсан байна.

Радио, телевиз, сонин хэвлэл зэрэг хуучин технологийн хувьд тэдгээрийн хэлбэр, мэдээлэл боловсруулах, хянах зэрэг нь төвлөрсөн бүтэцтэй, түгээх арга нь нэг чигийн урсгалтай. Харин интернэт мэтийн тоон технологи нь удирдлагыг төвлөрүүлдэггүй бөгөөд хувь хүн болон нийгмийн бүлгүүд удирдан зохион байгуулж, мэдээллийг хуваалцах, хамтран эзэмших боломжтой болсон байна.

МХХТ нь өнөөдөр нийгмийн олон салбарт, янз бүрээр хэрэглэгдэж байгаа жишээ цөөнгүй.

Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээнд МХХТ-ийг хэрэглэснээр Засгийн газрын үйл ажиллагааг нээлттэй, хэмнэлттэй болгохоос гадна төрөөс үзүүлэх үйлчилгээг илүү үр дүнтэйгээр иргэдэд хүргэх боломжийг бүрдүүлж болно. Засгийн газрын үйл ажиллагаа нээлттэй болсноор иргэдийн оролцоо нэмэгдэж, илүү хариуцлагатай, ардчилсан болно. Манай улсын засгийн газраас иргэдэд үзүүлэх үйлчилгээнүүддээ МХХТ-ийн дэвшлийг хэрэглэж, зохих дэвшил гарсаар байна.

¹ UNDP Evaluation Office, Information Communications Technology for Development, UNDP Essentials: Synthesis of Lessons Learned (New York: UNDP, 2001), 2.

Хүн бүрт чанартай боловсрол олгох нь улс орны хөгжилд ихээхэн ач холбогдолтой. Сургууль, цэцэрлэгийн хангалтгүй байдал, анги танхим, сурах бичиг болон бусад хэрэгсэл, багш нарын дутмаг байдлаас болоод боловсролын салбарын үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл учирдаг. Боловсролын салбарт МХХТ-ийг ашиглан багш, эцэг эх, суралцагчдын хамтын ажиллагааг хамгийн боломжит бага зардлаар хангаж, илүү үр дүн гаргах боломж бүрдүүлж болно.

Эрүүл мэндийн салбарт МХХТ-ийг ашигласнаар алслагдсан нутаг дэвсгэр дэх хүн амд эрүүл мэндийн үйлчилгээг бага зардлаар үр дүнтэй хүргэх боломж бүрдэнэ. Жишээ нь манай улсын хувьд газар нутаг өргөн уудам, хүн ам цөөн, цаг уурын эрс тэс байдал зэрэг нь эрүүл мэндийн үйчилгээг хүн бүрт хүргэхэд хүндрэлтэй байдаг.

Өнөөгийн "Мэдээлэлжсэн нийгэм"-д МХХТ нь эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, улмаар ядуурал, ажилгүйдлыг бууруулахад ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байна. Бизнес эрхлэгчид болон аж үйлдвэрийн салбар энэхүү мэдээллийн зуунаас маш их үр ашгийг хүртэж байгаа жишээ олон байна.

МХХТ-ийг ашиглан жижиг бизнес эрхлэгчид дотоодын болон гадаад харилцаагаа сайжруулах замаар зардлаа бууруулах, шинэ зах зээл эрэлхийлэх, дэлхий нийтээр шинэ хэрэглэгчдийг бий болгох, эрэлт нэмэгдүүлэх, агуулахын болон бараа материалын удирдлагыг сайжруулах, үргүй хаягдлыг бууруулах зэргээр өөрсдийн ашгийг нэмэгдүүлж байна.

компьютерийн хэрэглээ

КОМПЬЮТЕРИЙН ТЕХНИК ХАНГАМЖ

Компьютерийн техник хангамж гэдэг нь компьютерийн системийг бүрдүүлж буй физик элементүүдийн нэгдэл юм. Компьютерийн техник хангамжид компьютерийг бүрдүүлж буй бүрэлдэхүүн хэсгүүд болох дэлгэц, гар, хулгана, хадгалах байгууламжууд, сүлжээний карт, санах ой, эх хавтан гэх мэт биет эд ангиудыг авч үзнэ.

Компьютер (PC-Personal Computer)

Компьютер гэдэг нь өгөгдлийг өгөгдсөн заавар буюу програмын дагуу боловсруулж өөр хэлбэрт хувиргадаг тоон төхөөрөмж юм. Компьютерийн хүрээнд *ширээний компьютер,* зөөврийн компьютер, таблет, утасгүй төхөөрөмжүүд багтана.

Анхны ширээний компьютерийг 1981 онд IBM компани бүтээж байжээ. Орчин үеийн компьютерүүд нь анхны загварыг хадгалсан ч хүчин чадал болон дагалдах тоног хэрэгсэл, програм хангамж нь байнга шинэчлэгдэн сайжирсаар байна.

Компьютерийн порт

Компьютерийн порт нь компьютерийг түүний бүрэлдэхүүн хэсгүүдтэй, мөн бусад компьютер болон нэмэлт төхөөрөмжүүдтэй холбох үүрэгтэй. Компьютерт USB, сериал, параллель, сүлжээний гэх мэт портууд байдаг.

Ю Эс Би порт (USB-Universal Serial Port)

USB портыг ашиглан зөөврийн өгөгдөл хадгалах байгууламж буюу флаш дискнээс гадна гар утас, хэвлэх төхөөрөмж, дижитал камер зэрэг олон төхөөрөмжийг компьютерт холбодог.

Сүлжээний порт

Сүлжээний порт нь компьютерийг сүлжээнд холбох үүрэгтэй.

VGA порт (Video Graphics Array Port)

Энэ порт нь анх 1987 онд үйлдвэрлэгдсэн ба компьютерийг дэлгэцтэй холбоход хэрэглэгддэг. VGA кабель нь аналог дамжуулал хийх бөгөөд зөвхөн дүрс дамжуулдаг.

HDMI порт (High-Definition Multimedia Interface Port)

HDMI порт нь дуу болон дүрсийн дамжууллыг дэмждэг. Энэ нь 2002 оноос эхлэн хэрэглэгдэх болсон. Сүүлийн үеийн телевизорууд болон компьютерийн дэлгэцүүдээс бид энэхүү портыг харж болно.









Компьютерийн өгөгдөл санах байгууламжууд

Компьютерийн өгөгдөл санах байгууламжид мэдээлэл санах зориулалттай зөөврийн диск, хатуу диск, CD, DVD, Blu-Ray зэрэг багтана.

Хатуу диск /HDD-Hard Disk Drive/: Бух компютерт хатуу диск нь суурилуулагдсан байдаг ба түүн дээр үйлдлийн систем суудаг. Мөн бусад хэрэглээний програмууд ч энэ дискэн дээр сууж, ажиллана.

Сиди /CD-Compact Disc/: Одоо үед бараг бүх компьютер CD уншигчтай болсон бөгөөд хэрэглэгчид үүнийг энгийн өгөгдөл болон дуу хадгалахад голчлон хэрэглэдэг.

Дивиди /DVD-Digital Versatile Disc/: DVD уншигч төхөөрөмжөөр дамжуулан дээр нь бичигдсэн өгөгдлийг уншуулна. DVD-г видео хадгалахад голчлон хэрэглэдэг.

Ю эс би флаш диск /USB flash disk/: Энэ төрлийн зөөврийн санах байгууламжууд нь USB портоор компьютерт холбогдоно. Хэрэглэхэд хялбар. Багтаамжийн хувьд янз бүр байдаг ба сүүлийн үед 128GB хүртэл хэмжээтэй зөөврийн диск бий болсноор их хэмжээний өгөгдлийг хадгалах, зөөх боломжтой болсон.

Мемори карт /Memory card/: Энэ нь дотроо санах үүрэг бүхий микросхемийг агуулсан карт бөгөөд гар утас, дижитал камер, төрөл бүрийн тоглуулагчдад хэрэглэгддэг.

Blu-Ray: Энэ нь өндөр нягтралтай видео болон аудио файлыг хадгалах зориулалттай санах байгууламж.

Оролтын төхөөрөмжүүд

Оролтын төхөөрөмжүүд болох хулгана, гар, камер, дижитал аппарат зэргийн тусламжтай бид компьютерт өгөгдөл оруулдаг. Жишээ нь: Бидэнд баримт боловсруулах шаардлага гарсан бол эхлээд тухайн баримтыг үүсгэж, түүн дээр текст бичих хэрэгтэй болно. Үүний тулд бидэнд компьютерийн гар болон хулгана зайлшгүй хэрэгтэй.

Хулгана: Үйлдлийн систем дээр ажиллаж, үйлдэл гүйцэтгэхийн тулд хулгана хэрэглэх шаардлага тулгардаг. Хулганын тусламжтай бид тухайн зүйлийг сонгох, идэвхжүүлэх, ажиллуулах зэрэг үйлдлийг хийх боломжтой. Хулганыг компьютерт кабель эсвэл утасгүй аргаар холбодог.

Гар: Энэ нь компьютерт текст хэлбэрийн өгөгдөл оруулдаг төхөөрөмж юм. Компьютерийн хувьд салангид байдаг ба үндсэн процессортой кабелиар эсвэл утасгүй байдлаар холбогдоно. Харин зөөврийн компьютер дээр процессорт хавсаргагдсан байна.

> Вэб камер: Вэб камер гарснаар вэбийн хэрэглээ улам их болсон. Энгийн компьютерт энэ камерийг холбон дуу, дүрс зэргийг интернэтээр дамжуулж болдог бол сүүлийн үеийн ихэнх зөөврийн компьютерт вэб камер нь шууд суурилуулагддаг болсон.















Дижитал аппарат: Уламжлалт аппаратуудаас ялгагдах гол ялгаа нь буулгасан дүрсээ хальсан дээр биш харин жижиг мемори карт дээр хадгалж, үүнийгээ кмпьютерт шууд холбон зургуудаа хуулж авах боломжтой байдагт оршино.

Гаралтын төхөөрөмжүүд

Энэ төрлийн төхөөрөмжүүдэд дэлгэц, хэвлэгч, спикер зэрэг багтана.

Дэлгэц: Эхэн үеийн дэлгэц нь хуучин телевизийн технологийг ашигласан цахилгаан их хэрэглэдэг, овор ихтэй байсан бол сүүлийн үеийн хавтгай дэлгэцүүдийн цахилгааны хэрэглээ, овор, жин багассан. Дэлгэцийн хэмжээг инчээр тодорхойлох ба энэ нь дэлгэцийн диагоналийн урт бөгөөд 1инч = 2.5см байна.

Спикер: Зарим компьютерийн дэлгэцэд энэ төхөөрөмжийг суулгасан байдаг бол зарим тохиолдолд нэмэлт төхөөрөмж байдлаар компьютерт холбож өгдөг. Спикерийн тусламжтайгаар компьютерт байгаа аудио файлуудыг сонсож болно.





Хэвлэгч: Зарим үед компьютерт оруулсан мэдээллийг хэвлэх шаардлага гардаг ба үүнийг хэвлэгч төхөөрөмж гүйцэтгэдэг. Хэвлэгч төхөөрөмжүүдийг лазер ба бэхэн гэж 2 ангилдаг бөгөөд аль аль нь өөрийн давуу талуудтай. Лазер хэвлэгчийн хувьд богино хугацаанд их хэмжээний хэвлэлт хийх боломжтой байдаг бол бэхэн хэвлэгчид өнгөт хэвлэлийг удаан боловч чанарын өндөр түвшинд гүйцэтгэдэг.

Компьютерийн зөв хэрэглээ

Ихэнх хүмүүс тэдний биед үзүүлэх нөлөөллийг бодолгүйгээр компьютерийн ард олон цагаар суудаг. Буруу байрлуулсан дэлгэцийг харах, бөгтийж суух гэх мэт буруу суултаас болж бүхэл өдөржин анзааралгүйгээр өөрсдийн биеийг ядраасан байдаг. Энэ байдал нь урт удаан хугацааны явцад үүсдэг өвчин эмгэг тусах эсвэл стресстэх байдлаар таны эрүүл мэндийг хохирооход хүргэж болно. Иймээс ажлын орчны зохион байгуулалтыг сайжруулах замаар ачаалал, ядрал, гэмтлийг бууруулах боломжтой. Өөрөөр хэлбэл та тав тухтай, тайван байдалд ажиллах ёстой юм.

Таны ажлын орчны зохион байгуулалт

Зөөврийн компьютерийн хувьд удаан хугацаанд хэрэглэхээр загварчлагдаагүй байдаг. Түүний дэлгэц болон гар нь хэтэрхий ойрхон ба тэднийг илүү эвтэйхэн байрлалд байрлуулахаар салгах боломжгүй байдаг. Иймээс хэрэв та урт хугацаагаар зөөврийн компьютерийн ард суух бол тусдаа дэлгэц, эсвэл компьютерийн гар нэмж залгах нь хамгийн сайн арга байх болно. Доор үзүүлсэн зурганд компьютерийн ард хэрхэн зөв суух талаар тайлбарласан байна.



WINDOWS 7 ҮЙЛДЛИЙН СИСТЕМ

Үйлдлийн систем гэдэг нь компьютер дээр ажилладаг хамгийн чухал програм. Өөрөөр хэлбэл компьютерийг асаах үед хамгийн эхэнд ажиллаж, бусад програмуудыг удирддаг. Хэрэв таны компьютерт үйлдлийн систем байхгүй бол компьютер болон бусад програмуудыг та ашиглах боломжгүй. Үйлдлийн систем нь Windows XP, Windows Vista, Windows 7, Windows 8, Windows 10 гэх мэт олон төрөл байдаг. Мөн Apple компаний Mac OS X-ийг сүүлийн үед өргөн ашиглаж байна. Үүнээс *Windows 7* үйлдлийн систем дээр хэрхэн ажиллах талаар авч үзье.

Windows 7 үйлдлийн системийн эхлэл

- Windows 7 үйлдлийн системийг эхлүүлэхэд танаас системд нэвтрэх нууц үгийг асууж болно. Та нууц үгийг оруулж, системд нэвтрэх үед дараах дэлгэцийг харна.
- Бид үйлдлийн систем дээр ажиллах үед байнга ямар нэг цонхтой ажиллана. Тухайн цонхны хэмжээг өөрчлөх, хаах гэх мэт зайлшгүй мэдэж байх ойлголтуудтай танилцъя. Эдгээр



үйлдлийг туршиж, дадлага хийхдээ *Getting Started* цонхыг ашиглана. Хэрэв энэхүү цонх нь компьютерийг асаах үед автоматаар дэлгэц дээр гарахгүй бол та дараах дарааллын дагуу уг цонхыг нээгээрэй.

- 🗸 **Start** товч дээр дарна. (Дэлгэцийн зүүн доод
- ✓ *All programs*-г сонгоно.



- ✓ Гарах ба жагсаалтаас Accessories-г сонгоно.
- Accessories доторх дэд жагсаалтууд дэлгэцэд харагдах ба эндээс Getting Started-г сонгоно.
- Дээрх үйлдлийг дарааллын дагуу хийсэн бол бидний дадлага хийх дараах цонх дэлгэцэнд гарч ирнэ. Одоо уг цонхон дээр дадлага хийж, хэрхэн цонхыг зөөх, томруулах, жижигрүүлэх талаар авч үзье.



буланд байрладаг)



Цонхтой ажиллах

Цонх зөөх

Тухайн цонхыг зөөхийн тулд цонхны дээд хэсэгт байгаа сул зайн дээр хулганы зүүн товчийг дарсан хэвээр хулганыг шилжүүлнэ. Энэ хэсгийг *Title Bar* гэж нэрлэдэг. *Title Bar* дээр дарсан хэвээр хулганыг шилжүүлэхэд цонх түүнийг даган дэлгэцэн дээр шилжинэ. Хулганы товчийг сулласны дараа /дарахаа болих/ цонх тухайн шилжүүлсэн байрлал дээр ирнэ.

	Title Bar		_ D _ X
00	🗢 🗐 « All Control 🕨 Getting Started	✓ Search Control Panel	Q

Чирэх болон суллах /Drag and Drop/

Өмнөх жишээнд дурдсан хулганы зүүн товчийг дарсан байдлыг хадгалан хулганыг шилжүүлэх үйлдлийг чирэх /*dragging, drag/,* харин хулганын товчийг дарах байдлыг болих үйлдлийг суллах /*drop/* гэж нэрлэдэг.

Сонгох /Select/

Бид тухайн үйлдлийн систем дээр ажиллах үед байнга ямар нэг зүйлийг сонгож, тухайн сонгогдсон зүйл дээр үйлдэл хийдэг. Өөрөөр хэлбэл та сонирхсон зүйлээ юу болохыг үйлдлийн системд хэлэхийн тулд эхлээд сонгох хэрэгтэй. Харин дараа нь түүн дээр тодорхой үйлдлүүдийг хийнэ гэсэн үг юм. Жишээ нь: Таны хатуу дискэн дээр байрлаж байгаа файлыг нэг байрлалаас нөгөө рүү зөөхийн тулд та эхлээд тухайн файлыг сонгож, дараа нь түүнийг зөөнө.

Нэг товших, хоёр товших /Single clicking, double clicking/

Ихэвчлэн ямар нэг зүйлийг сонгох үед тухайн зүйл дээрээ хулганы сумыг байрлуулан зүүн товчийг нэг товшино. Харин та сонгосон ямар нэг зүйлээ ажиллуулах эсвэл нээхийн тулд түүн дээр хулганы сумыг байрлуулан зүүн товчийг ойрхон 2 удаа товших хэрэгтэй.

Цонхны хэмжээг өөрчлөх

Цонхны зүүн талын ирмэгт хулганы заагчийг байрлуулахад хулганы заагчийн хэлбэр 2 талдаа сумтай хөндлөн шулуун болж өөрчлөгдөнө. Ингэж хэлбэр нь өөрчлөгдөх үед хулганыг зүүн эсвэл баруун чиглэлд чирснээр цонхыг нарийн эсвэл өргөн болгоно. Хулганы товчийг суллах үед цонхны хэмжээ хулганыг аль чиглэлд шилжүүлснээс хамааран өргөн эсвэл нарийн болж өөрчлөгдсөн байна. Энэ үйлдлийг цонхны баруун талын ирмэгт хулганы заагчийг байрлуулан хийж болно.

Дээрхийн адил цонхны дээд эсвэл доод талын ирмэгт хулганы заагчийг байрлуулан цонхны хэмжээг өндөрсгөж эсвэл намсгаж болно.

Цонхны хэмжээг максимум болгох

Ямар ч цонхны баруун дээд буланд дараах гурван товч байна.

✓ Хэрэв та хулганы заагчийг гурван товчны голын товч дээр байрлуулбал уг тэмдгийн тайлбар болох *Maximize* гэсэн үг харагдана.



✓ Энэхүү товчийг Maximize гэж нэрлэх ба уг товч дээр хулганы заагчийг байрлуулах зүүн товчийг нэг дарахад цонх дэлгэц дүүргэн, хамгийн том хэмжээнд шилжинэ. Цонх хамгийн том хэмжээнд шилжсэний дараа дахин хулганы заагчийг голын товчин дээр байрлуулвал Restore down гэсэн тайлбар гарна.



✓ Цонх хамгийн том хэмжээнд шилжсэний дараа энэхүү голын товч дээр дарвал цонх анхны хэмжээндээ буцаж шилжинэ. /хамгийн том хэмжээнд шилжихээс өмнө байсан хэмжээнд/

Цонхны хэмжээг минимум болгох

✓ Та хулганы заагчийг гурван товчны эхний товч дээр байрлуулбал, түүнийг *Minimize* гэж нэрлэдэг болохыг харна.



✓ Хэрэв уг товч дээр дарвал цонх дэлгэц дээр харагдахгүй, дэлгэцийн доор хөндлөн байрлах **Taskbar** буюу ажлын мөр хэмээн нэрлэх хэсэгт минимум хэлбэрт шилжин, байршсан байна.



✓ Taskbar-т байрлах минимум хэмжээнд шилжсэн цонх дээр хулганы заагчийг байрлуулан зүүн товчийг нэг дарахад цонх дахин дэлгэц дээр гарч ирнэ.

Цонхыг хаах

✓ Хулганын заагчийг гурван товчны сүүлийн товч дээр байрлуулахад, Close гэсэн тайлбар гарна.



Start товч

Дэлгэцийн зүүн доод буланд байрлах дугуй хэлбэртэй товчийг **Start** товч гэж нэрлэдэг.



Start цэс

Start товч дээр дарахад *Start цэс* дэлгэцэнд дараах байдалтай харагдана. Энэ цэс нь таны ажиллуулж болох бүх програмуудын жагсаалтыг агуулж байдаг.



Зөвлөгөө: Start цэсийг дэлгэцэнд гаргахын тулд компьютерийн гар дээр байрлах **Windows** товчийг дарж болно. Компьютерийн гар бүр энэ товчийг агуулдаггүй ч ихэнх гар дээр байдаг.

Start цэсийг ашиглан програм ажиллуулах

- ✓ Start цэсийг нээж, All programs-г сонго.
- Жагсаалтаас Accessories гэсэн үгийг хайж олоод, түүн дээр дарахад цэс дараах байдалтай өөрчлөгдөнө. Notepad програмыг сонгож, дарснаар програмыг ажиллуулна.



Windows үйлдлийн системийг унтраах

 Компьютерийг унтраахын тулд Start цэсийг нээж, Shut down товч дээр дарна. Хэсэг хугацааны дараа таны компьютер унтарна.



Notepad програмыг хаахын тулд цонхны

баруун дээд

товчийг дарна.

Windows 7 Desktop

Desktop гэж юу вэ?

Компьютер асах үед та дэлгэц дээр байгаа файл, програм зэргийг дүрслэн үзүүлсэн жижиг дүрснүүдийг /*icon*/ олж харах болно. Эдгээрийг бид цаашид *icon* гэж ярих болно.

Getting Started	•
All Programs	
Search programs and files	٩
🔊 🚺 📀	

буланд байрлах хаах

Windows үйлдлийн систем ассаны дараа гарч ирэх дэлгэцийг *desktop* гэнэ. Энэ нь *icon* гэж нэрлэгдэх жижиг зурагнуудаас гадна дэлгэцийн бусад элементүүдийг агуулна.

Дэлгэц дээр байрлах дүрснүүд /Desktop icons/

Windows үйлдлийн системийн дэлгэц дээр байгаа жижиг дүрснүүд нь уг системийг суулгах үед хэрэглэгчийн өөрт тохируулан өөрчилсөн байдлаас хамааран компьютер бур дээр ялгаатай байж болно. Та дэлгэц дээр *icon* зөөж. нэмж, устгаж болно. Ерөнхийдөө дэлгэц нь дараах байдалтай харагддаг.



Дэлгэц дээрх icon-уудыг зөөх

✓ Хулганы заагчийг **Recycle Bin icon** дээр байрлуулан, хулганы зүүн товчин дээр дарах ба дарсан хэвээр дэлгэцийн өөр байрлалд хулганы заагчийг шилжүүлэн, хулганы товчийг суллах үед уг *icon* өөр байрлалд шилжинэ.



✓ Уг үйлдлээр дэлгэц дээрх бусад бүх *icon*-г зөөж болно.

Зөвлөгөө: Recycle Bin нь таны устгасан файлуудыг түр хадгалахад хэрэглэгддэг.

Windows Taskbar

Windows Taskbar нь дэлгэцийн доор хөндлөн байрлаж буй хэсэг юм. Үүнийг ажлын мөр гэж нэрлэдэг. Энэ нь *Start* товч болон баруун доод буланд байрлах цаг, мөн ажиллаж буй програмуудын icon зэрэг олон чухал зүйлсийг агуулдаг.

	10 C	1								1
9		0	0	2	Bolor - Mongolia	OS.docx - Micros	sample_windows	en 🤣	▲ 12:45 → 12:45 7/6/20	PM 012

Нуугдмал ісоп-уудыг харах

боломжтой.

✓ Windows Taskbar-н баруун талд Show Hidden icon хэрэгсэл байрлана.

	MN	8 •	•	۲	.ail	٦	Ф		:	6:16 2014	PM 1/8/4	4			
✓	Энэ	хэ	рэг	сэл	дээ	эр	даро	снаа	ар	та	нуу	угдг	мал	<i>ісоп</i> -уудыг	харах



✓ Энэхүү хэрэгсэл нь цөөн хэрэглэгддэг *icon*-уудад хандах боломжийг танд олгохоос гадна бүх *icon*-ууд *Taskbar* дээр зэрэгцэн байрлахгүй байхаар цэгцэлж өгдөг.

Дэлгэцийн тохиргоо

Дэлгэцийг өөртөө тохируулан өөрчлөх

- ✓ Дэлгэцийн хоосон хэсэгт хулганыг байрлуулж, баруун товчийг дарж, жагсаалтаас Personalize командыг сонго.
 ✓ Цонх нээгдэх ба Desktop Background товчийг дар.
 - See also Display Taskbar and Start Menu Ease of Access Center Desktop Background Harmony Window Color Sky
- View
 >

 Sort by
 >

 Refresh
 >

 Paste
 >

 Paste shortcut
 Undo Rename

 Undo Rename
 Ctrl+Z

 Graphics Properties...
 Graphics Options

 New
 >

 Screen resolution

 Gadgets

 Personalize
- ✓ Та дэлгэцийн арын дэвсгэрт ямар зураг тавихаа сонгоно.



Зевлегее: Цонхны баруун хэсэгт байгаа **scroll** буюу гүйх товчийг шилжүүлэн бусад зурагнуудыг харах боломжтой.

- Дэлгэц дээр байрлуулах зургаа сонгох үед таны дэлгэц сонгосон зургаар солигдоно.
- ✓ Дэлгэц дээр сонгосон зургаа байрлуулж, хэрэгжүүлэхийн тулд Save changes товчийг дарна.
- ✓ **Personalization** цонхыг хаана.



Дэлгэцийн дэвсгэр өнгийг өөртөө тохируулж өөрчлөх

- ✓ Өмнөхийн адил *Personalization* цонхыг нээж, *Desktop Background icon*-г сонго.
- ✓ Харилцах цонхны *Picture location* хэсгийн баруун талд байрлах суман дээр дарвал доошоо унасан жагсаалт гарч ирнэ. *Solid Colors*-г сонго.



- Дэлгэцэнд өөрчлөлт оруулахдаа зураг биш, харин өнгө солих боломжтой харилцах цонх гарч ирнэ.
- Сонгохыг хүссэн өнгө дээр дар. Та өнгийг сонгох үед таны дэлгэцийн дэвсгэр тухайн өнгөөр өөрчлөгдөхийг харна.

Зөвлөгөө: Цонхны баруун хэсэгт байгаа **scroll** буюу гүйх товчийг шилжүүлэн бусад өнгийг харах боломжтой.

Choose your	desktop backg make it vour deskto	round	ct more than one	picture to create a slid	e show.
Picture location:	Solid Colors		• Brows	e	
					-
					Ξ
					-
More					

- ✓ Сонгосон өнгөө баталгаажуулахын тулд Save changes товчийг дар.
- ✓ Personalization цонхыг хаана.

Screen saver-н тохируулга

Хэрэглэгч тодорхой хугацаанд идэвхгүй байх буюу хулгана, эсвэл компьютерийн гараас ямар ч үйлдэл хийгдээгүй үед компьютерийн дэлгэцнээ хөдөлгөөнт зураг гарч ирдэг. Үүнийг **Screen saver** гэнэ.

- Personalization цонхыг нээнэ.
- ✓ Screen saver товчийг дарах үед Screen Saver Settings харилцах цонх гарч ирнэ.



- Screen saver-н төрлүүдээс сонгохын тулд Screen saver хэсгийн доошоо харсан суман дээр дарах үед гарах жагсаалтаас жишээ болгон *Ribbons*-г сонгоё.
- ✓ Wait хэсэгт байрлах дээш, доош харсан сумаар хэдэн минутын дараа Screen saver ажиллаж эхлэх хугацааг зааж өгнө. Preview товч дээр дарж, тухайн сонгосон

Screen saver	
(None) 👻	
(None) 3D Text Blank Bubbles Mystify Photos	un ar
Ribbons Windows Live Photo Gallery	

Screen saver-г урьдчилан үзэж болно.

Screen saver		
Ribbons 👻	Settings	Preview
Wait: 1 📄 minutes 🔲 On resu	ıme, display logon s	screen

- ✓ Сонгосон Screen saver-ээ хэрэгжүүлэхийн тулд OK товч дээр дарж, харилцах цонхыг хаана.
- ✓ Personalization цонхыг хаана.

Компьютерийн хэл болон бүсийн тохируулга

- ✓ Start товч дээр дарж, гарч ирэх Start цэсээс Control Panel товчийг сонго.
- Control Panel цонхонд байрлах тохируулгын сонголтуудаас Clock, Language, and Region холбоосыг сонго.
- Clock, Language, and Region харилцах цонх гарч ирнэ. Change location холбоос дээр дар.



✓ Гарч ирэх цонхны *Current location* хэсэгт байрлах доош харсан суман дээр дарвал улс, орнуудын жагсаалт гарах ба өөрийн орныг сонгож өгнө.

Segion and Language
Formats Location Keyboards and Languages Administrative
Some software, including Windows, may provide you with additional content for a particular location. Some services provide local information such as news and weather.
Current location:
United States

✓ Тухайн цонхны *Keyboards and Languages* табын *Change keyboards* товч дээр дар.



✓ Гарч ирэх харилцах цонх танд үндсэн оролтын хэлийг өөрчлөх болон сонгох боломжийг олгоно. Хэрэв та оролтын хэлийг нэмэхийг хүсвэл Add товч дээр дарна. Гарах хэлний жагсаалтаас сонгоод OK товч дээр дар.

Text Services and Input Languages	
General Language Bar Advanced Key Settings	
Default input language Select one of the installed input languages to use as the default for all input	Add Input Language
neids. English (United States) - US	Select the language to add using the checkboxes below.
	tale) (India) Cancel
Select the services Select the services shown in the list.	Maltese (Malta)
Use the Add and Remove buttons to modify this list.	Maori (New Zealand)
EN English (United States)	Mapdoungun (Crine)
Keyboard	Hohawk (Mohawk)
	- Mongolian (Cyrillic, Mongolia)
Add	Mongolian Cyrillic
Remove	US E
Properties	Show More
Marine Line	Mongolian (Traditional Mongolian, PRC)
Move op	⊕ Norwegian, Bokmål (Norway)
Move Down	Norwegian, Nynorsk (Norway)
	Occitan (France)
	⊕ Oriya (India)
OK Cancel Apply	

✓ Одоо таны компьютер 2 хэлний сонголттой боллоо. / Англи, Монгол/



Нээлттэй ажиллаж байгаа програм хооронд шилжих

Та компьютер ашиглаж байхдаа хэд хэдэн програмын нээн ажиллуулдаг. Эдгээр програм хооронд хулгана ашиглалгүй, гарын товчлуураар хэрхэн шилжих талаар авч үзье. Дэлгэц дээр *Getting Started* цонх, *Notepad, Calculator* гэсэн програмуудыг ажиллуулъя.

						-	. 🗆 💌
4	Untitled - Notepad		Control Pa	anel 🕨 All Control Panel It	erns 🕨 Getting Started		٩
Acci	File Edit Format V	iew Help		Go online to fin • Discover new features tha • Find out everything you n	d out what's new in Wi can help you be productive, stay safer, eed to know about setting up your com	and have fun puter & Go online to I	
SUB		MC M ← C	Go online to find windows 7	out what's new in share with in your home	Personalize Windows Choose when to be notified about changes to your computer	Transfer files and settings from another computer	IIC.
	kiopies Intensi Epilore S Java J E P	4 5 1 2 0	Add new users to	your computer	Change the size of the text on your screen		
in dae Bas	e Studio	The second secon					

- Calculator програмаас бусдыг нь бид хэрхэн нээх талаар өмнө нь үзсэн билээ.
 Calculator програмыг нээхийн тулд Notepad, Getting Started програмыг нээсэнтэй ижил үйлдэл хийнэ.
- ✓ Дээрх 3 цонхны хооронд шилжихдээ компьютерийн гар дээрх Alt товчийг дарсан

хэвээр **Таb** товчийг нэг удаа дар. /Alt товч дээр дарсан хэвээр байна/ Энэ үед дэлгэцийн дунд нээлттэй /ажиллаж/ байгаа бүх цонхнууд дараах байдалтай харагдана.



✓ Харин одоо *Alt* товч дээр дарсан хэвээр, *Tab* товчийг хэд хэдэн удаа дарвал тухайн нээлттэй байгаа бүх цонх хооронд дарааллын дагуу шилжинэ. Та дарааллын дагуу шилжүүлж, өөрийн хүссэн цонхон дээр ирэх үед *Alt* товчийг суллах ба энэ үед дэлгэц дээр таны сонгосон цонх гарна.

Шууд хүргэх холбоосыг үүсгэх, түүний хэрэглээ /Shortcut/

Ерөнхийдөө **Shortcut** гэдгийг ямар нэг файл, хавтас, програм зэрэгт хандаж, тэднийг нээх үйлдэлд зарцуулагддаг хугацааг багасгасан илүү богино зам гэж ойлгож болно. Бид өмнө нь **Start цэсээс** тухайн програмаа сонгон, хэрхэн ажиллуулах талаар авч үзсэн билээ. Харин одоо **shortcut icon** ашиглан тухайн зүйлдээ илүү хурдан хугацаанд хандаж болох талаар үзье. Жишээ болгон бидний мэдэх **Getting Started** цонхны хувьд **shortcut** үүсгэе.



- ✓ Start товчийг дарж, All Programs-г сонгон, Accessories бүлэгт ханд.
- Accessories-н бүлэг доторх жагсаалтаас Getting Started програмын icon дээр хулганын баруун товчийг дарна. Гарч ирэх цэсээс Send to командыг сонгоход дахин дэд цэс гарах ба түүнээс Desktop (create shortcut) командыг сонгоно.
- ✓ Дэлгэц дээр дараах *icon* шинээр нэмэгдсэн байна.



✓ Дэлгэц дээрх уг *icon* дээр хулганаараа 2 товшвол *Getting Started* цонх нээгдэнэ.

Файлын зохион байгуулалт

Файл болон хавтас

Аливаа програм файлуудын олонлогоос бүрддэг. Энэ файлуудыг дараах үндсэн хоёр төрөлд хувааж үзнэ. Үүнд:

- 1. **Програмын файлууд / Командын файлууд** эдгээр нь програмист буюу тухайн програмыг бүтээсэн үйлдвэрлэгчдийн бичсэн файлууд байна. Энгийн хэрэглэгчид энэ төрлийн файлын агуулгыг мэдэх шаардлагагүй.
- 2. **Өгөгдлийн файлууд / Хэрэглэгчийн файлууд** хэрэглэгчийн захиа, албан баримт, хүснэгт, зураг мэтийн файлууд.

Файл болон хавтаснуудын зохион байгуулалт

Програм суух явцдаа автоматаар програмын файлуудын зохион байгуулалтыг хийдэг. Харин хэрэглэгчийн файлуудын хувьд зохион байгуулалтыг хэрэглэгч та өөрөө хийх шаардлагатай.

Компьютерийг олон шургуулга бүхий шүүгээ гэж төсөөлбөл шургуулга бүр нь таны компьютер дээрх хатуу диск, флаш диск, сиди мэтийн санах байгууламжуудыг төлөөлнө. Зарим байгууллагад шүүгээний шургуулгануудад албан баримтуудаа хавтаснуудад төрөлжүүлэн хийсэн байдаг. Энэ нь компьютерийн аль нэг дискэн дээрх хавтастай төстэй. Компьютерийн хавтаснууд ч мөн төрөлжүүлсэн мэдээллийг агуулдаг.

Жишээ нь, оюутан хичээлтэйгээ холбоотойгоор үүсгэсэн файлуудаа нийтэд нь 'Сургууль' хавтсанд хадгалж болох ба үүнийгээ цааш нь хичээлүүдээр төрөлжүүлэн задалж болно.



Хавтсан доторх хавтсыг дэд хавтас гэх бөгөөд нэг хавтсанд хэдэн ч дэд хавтас, файл байж болно. Харин файл дотор файл байж болохгүй.

Файл болон хавтаснуудыг зохион байгуулахдаа Windows Explorer цонхыг ашиглаж болно.

Дүрслэл	Илэрхийлэл
Англи хэл	Дотроо дэд хавтас болон файл агуулж болох <u>хавтас</u> . Хавтсыг хэрэглэгчид өөрсдийн файлуудаа зохион байгуулалттай болгох зорилгоор хэрэглэдэг.
Toouoo.xls	MS Windows-ын өгөгдөл хадгалах үндсэн нэгж болох <u>файл</u> . Файлууд нь зураг, баримт, хүснэгт гэх мэт олон төрөлтэй. MS Windows файлыг төрлөөс нь хамааруулан ялгаатайгаар дүрсэлдэг. Жишээ болгон авсан Тооцоо.xls файлын дүрслэл нь уг файл MS Excel програмаар үүсгэгдсэнийг харуулж байна.

Файл болон хавтаснуудыг хадгалах

Файл нь өгөгдлийн олонлогийг хадгалдаг нэгж. Компьютер дээрх бараг бүх мэдээлэл файл хэлбэрээр хадгалагддаг. Файлын төрөл нь хадгалах өгөгдлийн төрлөөсөө хамаарна. Жишээ нь, текст файлууд текстэн өгөгдлийг, зургийн файлууд зурган өгөгдлийг хадгална. Файлын нэр нь тухайн файлын онцлогийг харуулсан нэр, түүний төрлийг нь тодорхойлох өргөтгөл гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Жишээ нь: **Төсөв.docx** файлын хувьд нэр нь **Төсөв**, өргөтгөл нь **docx** болно.

Хавтас нь файлуудыг агуулна.

Windows Explorer цонх

Windows Explorer цонхыг ашиглан бид компьютерийн санах байгууламжуудыг харахаас гадна компьютер дээрх файлуудыг удирдах боломжийг бүрдүүлнэ. Үүнийг өөрөөр файл системийн хөтөч гэж хэлж болох юм.



Windows Explorer цонхыг нээхийн тулд дараах 2 аргын нэгийг хэрэглэж болно.

- Start товч дээр хулганын баруун товчийг дарж гарах жагсаалтаас Open Windows Explorer командыг сонгоно.
- Компьютерийн гар дээрх цонхны зураг бүхий *Windows* товчийг *E* үсгийн хамт дарна.

Энэ компьютер гурван хатуу диск нэг DVD RW төхөөрөмжтэй байна. Дискнүүд нь Англи хэлний цагаан толгойн үсгийн дарааллын дагуу нэрлэгддэг.

- С: Үндсэн хатуу диск.
- **D:** Хоёрдогч диск.
- Е: Гуравдагч диск.
- F: DVD-RW төхөөрөмж.

Хэрэв өөр зөөврийн санах байгууламжуудыг нэмж компьютерт холбовол G: H: гэх мэт үргэлжлэн нэрлэгдэнэ.

Файл болон хавтаснуудын харагдах хэлбэр

Компьютер доторх файл, хавтаснуудын харагдацыг тохируулах хэд хэдэн сонголт байдаг.

Windows Explorer цонх хоёр хэсэгт хуваагдана. Зүүн талд, диск болон хавтаснуудын жагсаалтыг хэлбэрээр мод дүрсэлнэ. Цонхны баруун талд, өөрсдийн онцлог дүрслэл бүхий хавтас, файлууд дүрслэгдэнэ. Энэ хавтас, файлууд нь цонхны зүүн хэсгийн идэвхтэй диск эсвэл хавтас доторх хавтас, файлууд юм.

Windows нь хавтсан доторх агуулгыг харах хэд хэдэн



сонголтыг хэрэглэгчдэд олгодог. Харагдацыг тохируулахын тулд:

1. Харагдацыг сонгох командын товчны баруун талд байрлах доошоо харсан суман дээр дарна.



2. Гарч ирэх сонголтуудаас өөрийн хүссэн харагдацыг сонгоно. Сонголтуудыг дараах хүснэгтэд тайлбарлав.

Сонголт	Үйлдэл
Extra Large Icons	Таны хавтас, файлуудын icon-г хамгийн том хэмжээтэй болгож, нэрний хамт харуулна.
Large Icons	Таны хавтас, файлуудын icon-ны хэмжээг томруулж, нэрний хамт харуулна.
Medium Icons	Таны хавтас, файлуудын icon-г дундаж хэмжээтэй болгож, нэрний хамт харуулна.
Small Icons	Таны хавтас, файлуудын icon-ны хэмжээг жижигрүүлж, нэрний хамт харуулна.
List	Файл болон хавтаснуудын нэрсийг жижиг icon-той хамт жагсаалт үүсгэн харуулдаг.
Details	Идэвхтэй хавтсан доторх файл болон хавтаснуудыг нэр, төрөл, хэмжээ ба өөрчлөлт хийсэн огноотой хамт жагсаан харуулдаг.
Titles	Файл болон хавтаснуудын нэр болон icon-г зарим бусад мэдээлэлтэй хамт харуулдаг.
Content	Файл болон хавтаснуудын нэр болон icon-г зарим бусад шинж чанартай хамт харуулдаг.

Файлууд

Бид хэрэгтэй мэдээллээ компьютерт хадгалдаг. Энэ мэдээлэл нь файлд хадгалагддаг бөгөөд ямар нэг мэдээллийг анхны удаа хадгалахад файлд нэр өгөн хадгалдаг. Мэдээллийг компьютероос хайх болон дахин нээхэд файлын нэр чухал үүрэгтэй.

Зевлегее: MS Windows үйлдлийн систем нь файлын нэрийг хамгийн ихдээ 255 тэмдэгт байхыг зөвшөөрдөг бөгөөд \? : * " < > тэмдэгтүүдийг файлын нэрэнд оруулахыг зөвшөөрдөггүй.

Файлуудыг эрэмбэлэх

Файлуудыг дэлгэрэнгүй байдлаар (*Details*) харах тохиргоог хийхэд үйлдлийн систем файлуудын нэр, хамгийн сүүлд өөрчлөлт хийсэн огноо, төрөл болон хэмжээг харуулна.

New folder	Файлуудын харагдацын 1	Details 🖒 💷	- 🗌 🔞
Documents library Bie_daalt	сонголтыг сонгосон	I. Arrange by:	Folder 🔻
Name	Date modified	Туре	Size
퉬 classes	2013/11/11 6:56 PM	File folder	
🌗 src	2013/11/11 10:38	File folder	
國 Bie_daalt.jcp	2013/11/30 10:36	JCP File	2 KB
📄 Bie_daalt.jcu	2013/11/30 10:36	JCU File	2 KB

Энэ харагдацыг ашиглан бид нэр болон бусад шинжээр нь файлуудыг эрэмбэлж болно.

Үүний тулд юугаар эрэмбэлэхээ сонгож, тухайн талбар дээр дарна.

Сонголбор	Үйлдэл
Name/Hэp	Файлуудыг нэрээр эрэмбэлнэ.
Date modified/Өөрчлөлт хийсэн огноо	Хамгийн сүүлд хадгалсан огноогоор нь файлуудыг эрэмбэлнэ.
Туре/Төрөл	Файлыг төрлөөр эрэмбэлнэ.
Size/Хэмжээ	Файлуудыг хэмжээгээр нь өсөх буюу буурахаар эрэмбэлнэ.

Хавтас үүсгэх

Хавтас үүсгэхийн тулд:

- 1. Windows Explorer цонхон дээр хавтас үүсгэх диск эсвэл хавтсыг сонгоно.
- 2. Toolbar буюу хэрэгслийн мөрнөөс **New Folder** командын товчийг дарахад шинэ хавтас үүснэ.

	-	_	- 2	-		-		×
Gv	Computer	Local Disk (C:) 🕨	•	47	Search Local Disk	: (C:)	٩
Organize 💌	Share with 💌	Burn	Compa	atibility f	iles	New folder		?

3. Гарч ирэх шинэ хавтасны нэрний хэсэгт хавтасныхаа нэрийг бичнэ.





沾 SQL Server Management Studio

4. Enter товч дарна. Шинэ хавтас үүслээ.

Файл, хавтас болон дэд хавтаснуудыг дахин нэрлэх

- 1. Windows Explorer цонхон дээр дахин нэрлэх файл, хавтас буюу дэд хавтсыг сонгоно. (Хулганын зүүн товчоор нэг товшино).
- 2. Сонгогдсон файл, хавтас буюу дэд хавтсан дээр хулганын баруун товчийг дарна.
- 3. Гарч ирэх командын цэсээс **Rename** командыг сонгоно.
- 4. Хуучин нэр бүхий хэсэгт шинэ нэрийг оруулна.

1	LAB_09 <mark>.doc</mark>
P	LAB_10.doc
2	University.mdb

💾 Ла6_09.doc	
LAB_10.doc	
University.m	db

	Send to
	Cut Copy
	Create shortcut Delete
	Rename
	Open folder location
	Properties

5. Enter товч дарна.

Анхаар:

- Нээлттэй буюу ашиглагдаж байгаа файлын нэрийг өөрчлөх боломжгүй.
- о Файлыг шинээр нэрлэхдээ өргөтгөлийг нь өөрчилж болохгүй. Өргөтгөл нь уг файлыг
- ямар програмаар нээхийг тодорхойлж өгдөг учраас өргөтгөлийг өөрчилсөн тохиолдолд уг файлыг нээх програмыг систем тодорхойлж чадахгүйд хүрнэ.
- Файлын өргөтгөлийг өөрчлөх оролдого илэрсэн үед систем дараах мэдээллийг гаргана.

Rename	
▲	If you change a file name extension, the file might become unusable. Are you sure you want to change it?
	Yes No

Файл, хавтас болон дэд хавтаснуудыг сонгох

Тодорхой нэг файл, хавтас буюу дэд хавтсыг сонгохдоо:

 Windows Explorer цонхон дээр сонгох файл, хавтас буюу дэд хавтас дээр хулганын зүүн товчоор нэг удаа товшино. Сонгогдсон файл, хавтас буюу дэд хавтас тодорч харагдах ёстой.

Зэргэлдээ орших хэд хэдэн файл, хавтас буюу дэд хавтаснуудыг сонгохдоо:

- ✓ Windows Explorer цонхон дээр, эхний файлыг хулганын зүүн товчоор нэг товшиж сонгоно.
- ✓ Гарны SHIFT товчлуурыг дарж, дарсан хэвээр сонгох бүлгийн сүүлийн файлыг хулганын зүүн товчоор товшиж сонгоно.
- ✓ SHIFT товчийг дарахаа болиход файл, хавтас буюу дэд хавтасны бүлэг сонгогдоно.

Бие биетэйгээ зэргэлдээ байрлаагүй хэд хэдэн файл, хавтас буюу дэд хавтаснуудыг сонгохдоо:

- ✓ Windows Explorer цонхон дээр, эхний файлыг хулганын зүүн товчоор нэг товшиж сонгоно.
- ✓ Гарны **CTRL** товчлуурыг дарж, дарсан хэвээр сонгох бусад файл, хавтас буюу дэд хавтаснуудыг хулганын зүүн товчоор дарна.
- ✓ CTRL товчийг дарахаа болиход файл, хавтас буюу дэд хавтаснууд сонгогдоно.

Файл, хавтас буюу дэд хавтаснуудыг хуулах

- ✓ Windows Explorer цонхноос дээрх аргуудын нэгийг ашиглан хуулах файл, хавтас буюу дэд хавтаснуудыг сонгоно.
- ✓ Хулганын баруун товчийг товшиж, гарах цэсээс Сору командыг хулганын зүүн товчоор товшин сонгоно.
- ✓ Сонгосон файл, хавтас буюу дэд хавтаснуудыг хуулах диск буюу хавтсыг сонгоно.
- ✓ Уг сонгосон хавтсан дээр хулганын баруун товчийг дарж, гарах цэсээс Paste командыг хулганын зүүн товчоор товшин сонгоно.

Зөвлөгөө:

- ✓ Дээрх алхмын 2 ба 3-ын оронд гарны **CTRL + С** товчны хослолыг дарж болно.
- ✓ Дээрх алхмын 5 ба 6-ын оронд гарны **CTRL + V** товчны хослолыг дарж болно.

Файл, хавтас буюу дэд хавтаснуудыг зөөх

- ✓ Windows Explorer цонхноос хуулах файл, хавтас буюу дэд хавтаснуудыг сонгоно.
- ✓ Хулганын баруун товчийг товшиж, гарах цэсээс Cut командыг хулганын зүүн товчоор товшин сонгоно.
- ✓ Сонгосон файл, хавтас буюу дэд хавтаснуудыг хуулах диск буюу хавтсыг сонгоно.
- ✓ Уг сонгосон хавтсан дээр хулганын баруун товчийг товшиж, гарах цэсээс **Paste** командыг хулганын зүүн товчоор товшин сонгоно.

Зөвлөгөө:

- ✓ Дээрх алхмын 2 ба 3-ын оронд гарны CTRL + X товчны хослолыг дарж болно.
- ✓ Дээрх алхмын 5 ба 6-ын оронд гарны CTRL + V товчны хослолыг дарж болно.

Файл, хавтас болон дэд хавтаснуудыг устгах

Хэрэглэгчийн дискнээс устгасан файл, хавтас буюу дэд хавтаснууд *Recycle Bin* буюу хогийн саванд байрладаг. Файл, хавтас буюу дэд хавтаснуудыг устгахдаа:

- ✓ Windows Explorer цонхноос устгах файл, хавтас буюу дэд хавтаснуудыг сонгоно.
- ✓ Гарны **Delete** товчийг дарна. Устгах эсэхийг баталгаажуулах харилцах цонх гарч ирнэ.
- ✓ Энэ харилцах цонхны Yes товчийг дарснаар файл *Recycle Bin* буюу хогийн саванд илгээгдэнэ. Хэрэв хогийн савны зураг хоосон байсан бол дүүрэн болох ёстой.



Анхаар:

- Зөөврийн санах байгууламжаас устгасан файлууд бүрмөсөн устдаг бөгөөд Recycle Bin буюу Хогийн сав руу илгээгддэггүй.
- ✓ Та файл, хавтас болон дэд хавтсыг устгахдаа гарны SHIFT + DEL товчны хослолыг ашиглаж болно. Гэвч энэ тохиолдолд таны файл хогийн сав руу илгээгдэхгүй, дискнээс бүр мөсөн устдаг тул анхааралтай хэрэглэнэ үү.

Хогийн сав дахь файл, хавтас буюу дэд хавтсуудыг сэргээх

Хогийн сав руу илгээгдсэн зүйлсийг тэндээс нь устгах команд өгөөгүй тохиолдолд хадгалагдаж байдаг. Эдгээр нь хатуу дискэн дээр тодорхой хэмжээний зай эзэлсэн хэвээр байдаг бөгөөд тэднийг бүрмөсөн устгах, эсвэл хуучин байр руу нь буцаан сэргээж болно.

Файл буюу хавтсыг буцаан сэргээхдээ:

- Windows Explorer дээрээс эсвэл desktop дэлгэцээс, Recycle Bin буюу Хогийн савыг хулганын зүүн товчоор хоёр товшин нээнэ.
- ✓ Сэргээх файл буюу хавтсыг сонгон, хулганын баруун товчийг дарахад командын цэс гарч ирнэ.
- ✓ Restore командыг хулганын зүүн товчоор товшин сонгоно.

Хогийн саван доторх бүх зүйлсийг буцаан сэргээхдээ:

- ✓ Windows Explorer дээрээс, эсвэл desktop дэлгэцээс Recycle Bin буюу Хогийн савыг хулганын зүүн товчоор хоёр товшин нээнэ.
- ✓ Toolbar буюу хэрэгслийн мөрнөөс **Restore All Items** командыг сонгоно.

				x
🕞 🔾 🗢 💽 🕨 Recycle Bin	✓ 4 Search R	ecycle Bin		٩
Organize 👻 Empty the Recycle Bin	Restore all items			0
Desktop	Карчиг Місгоз 20,5 КВ	.docx oft Word Do	cumen	t

✓ Сэргээх эсэхийг баталгаажуулах харилцах цонх гарч ирнэ.

W	∏ Fa	а <mark>рчиг.docx</mark> licrosoft Word Docum	ent
		Restore	
		Cut	
		Delete	
		Properties	



✓ Yes товчийг дарна.

Хогийн савыг хоослох

Хогийн савыг бүрэн хоослох буюу бүх зүйлийг бүрмөсөн устгахдаа:

- Windows Explorer дээрээс эсвэл desktop дэлгэцээс, Recycle Bin буюу Хогийн савыг хулганын зүүн товчоор хоёр товшин нээнэ.
- ✓ Toolbar буюу хэрэгслийн мөрнөөс Empty the Recycle Bin командыг сонгоно.



Анхаар: Хогийн савнаас устгагдсан зүйлс бүрмөсөн устдаг бөгөөд тэднийг эргүүлэн сэргээх боломжгүй.

Файл болон хавтас хайх

Файл болон хавтсыг хайхдаа:

- ✓ Start товчийг дарна.
- Search programs and files хэсэгт хайх програм эсвэл файл, хавтасныхаа нэрийг бичнэ.
- Хайлтын үр дүнг харуулах цонх гарч ирнэ.

Search programs and files

Зургийн аппаратаас зургийн файлыг компьютерт хуулах

Зургийн аппаратаас зураг компьютерт хуулах хэд хэдэн арга байдаг.

1. Зургийн аппаратын USB кабель ашиглан зураг компьютерт оруулах.

- ✓ Та дижитал аппарат гэх мэт мэдрэмтгий электрон төхөөрөмжүүдийг компьютерт холбох болон залгах үедээ эхлээд үнтраах хэрэгтэй.
- ✓ Холбогчийн нэг үзүүрийг аппаратад, нөгөө үзүүрийг компьютерийн USB порт руу хийнэ үү.





✓ Зургийн аппаратыг асаах ба таны компьютерт зургийн аппарат нэг диск болон нэмэгдэж орж ирнэ.





✓ Та нэмэгдсэн диск дээр дарж, зургуудад хандан, өөрийн компьютерт хуулах, зөөх үйлдлийг хийх боломжтой. 5 <u>x</u>.

1



2. USB карт уншигч ашиглан зураг компьютерт оруулах.



- ✓ Танд SD карт уншигч байх хэрэгтэй. Та карт уншигчийг компьютерийн USB порт руу шууд холбох, эсвэл USB кабель ашиглан уг порт руу холбоно.
- ✓ Зургийн аппаратын SD мемори картыг авч, карт уншигчид хийнэ. /Мемори картыг аппаратаас авахын өмнө түүнийг унтраахыг анхаарна уу. /



✓ Мемори карт таны компьютерт нэг диск болж нэмэгдэж орж ирнэ. Та нэмэгдсэн диск дээр дарж, зургуудад хандан, өөрийн компьютер луу хуулах, зөөх үйлдлийг хийх боломжтой.

25





3. Зөөврийн компьютерийн карт уншигч ашиглах





- ✓ Таны зөөврийн компьютерт суурилуулагдсан карт уншигч руу зургийн аппаратын мемори картыг хийнэ. /Мемори картыг аппаратаас авахын өмнө түүнийг унтраахыг анхаарна уу. /
- ✓ Мемори карт таны компьютерт нэг диск болж нэмэгдэж орж ирнэ. Та нэмэгдсэн диск дээр дарж, зургуудад хандан, өөрийн компьютер луу хуулах, зөөх үйлдлийг хийх боломжтой.



Дотоод сүлжээ /LAN/

Дотоод сүлжээ буюу LAN (Local Area Network)

Дотоод сүлжээ нь сургууль, албан газар, компьютерийн лаборатори гэх мэт орон зайн хувьд ихэвчлэн жижиг талбайг хамарсан, сүлжээний хэрэгсэл ашиглан хоорондоо холбогдсон, компьютерүүдийн харилцаа холбоог хэлнэ. Та дотоод сүлжээгээр групп дэх бусад хэрэглэгчидтэй өгөгдөл солилцох боломжтой. Жишээ нь, та өөрийн компьютероос найзынхаа компьютерт хандаж, файл авахыг хүсч болох юм. Энэ үед та дотоод сүлжээнд холбогдох тохируулгыг хийх хэрэгтэй, эсвэл эдгээр 2 компьютерийг кабелиар холбож болно. Ингээд хэрхэн дотоод сүлжээнд холбогдох болон файл хамтран хэрэглэх тохируулгуудын талаар үзье.

Ажлын групп үүсгэх

✓ Ta Windows Explorer цонхыг нээж, My Computer дээр хулганын баруун товчийг дарах ба гарч ирэх цэсээс **Properties** командыг сонго.

🖻 🔣 Homegroup			
4 🜉 Computer			
🛛 🚰 Local Disk (C:)	1	Collapse	
🖻 🧰 Data (D:)	۲	Manage	
		Open in new window	
🛛 📬 Network		Map network drive	
		Disconnect network drive	
		Disconnect network drive	
		Add a network location	
		Delete	
		Rename	
		Properties	
	_		
арч ирэх і	цон	іхны баруун доод	хэсэ

байрлах Change settings холбоос дээр дар.

✓ System Properties харилцах цонх гарч ирнэ.

 \checkmark

🗑 Change settings

Change товчийг дар.

System Properties	x
Computer Name Hardw	are Advanced System Protection Remote
Windows use	es the following information to identify your computer rk.
Computer description:	
	For example: "Kitchen Computer" or "Mary's Computer".
Full computer name:	SARAA
Workgroup:	WORKGROUP
To use a wizard to join - Network ID.	a domain or workgroup, click Network ID
To rename this compute	er, click Change. Change
	<u> </u>
	OK Cancel Apply

✓ Та өөрийн компьютерийн нэр болон группын өөрчлөх нэрийг бичиж, ОК товчийг дарна.

Computer Name/Domain Changes
You can change the name and workgroup membership of this computer. You cannot join a <u>computer running</u> Windows 7 Home Premium to a domain. <u>More information</u>
Computer name:
Full computer name:
More
Member of
O Domain:
Workgroup:
OK Cancel

 Та дээрх өөрчлөлтүүдийг хийснээр таны компьютер *restart* хийгдэх буюу унтарч, дараа нь асах ёстой. Иймээс компьютер унтрахаас өмнө, нээлттэй файлуудыг хадгалж, бүгдийг нь хаана. ОК товчийг дар.



✓ Таны компьютер унтраад, асах үед шинэ групп үүсгэгдсэн байна.

Компьютерт сүлжээний карт суурилуулагдсан болон драйвер нь танигдсан эсэхийг шалгах

✓ Start цэсийн Control Panel товчийг сонгосноор, системийн тохиргоо хийх цонх гарна.

Control Panel

✓ Systems-г сонгох ба түүний дараа цонхны зүүн хэсэгт байрлах Device Manager холбоосыг дар.

	Control Panel Hor	ne
0	Device Manager	
۲	Remote settings	
۲	System protection	
۲	Advanced system	settings

✓ Хэрэв сүлжээний карт танигдаагүй бол шар гурвалжин тодор анхаарлын тэмдэг бүхий тэмдэглэгээ харагдана.

E Computer Management	
File Action View Help	
🗢 🔿 🙍 🖬 🚺	
Computer Management System Tools System Tools Computer Nanagement System Tools Shared Folders Shared Folders Sorage Storage Storage Storage Storage Sorage Sorvices and Applicat	 ZOLOO-HP Batteries Biometric Devices Computer Disk drives Display adapters DVD/CD-ROM drives Human Interface Devices H Human Interface Devices IDE ATA/ATAPI controllers IDE ATA/ATAPI controllers Intel(R) Centrino(R) WiMAX adapters Keyboards Mice and other pointing devices Monitors Network adapters Network adapters Intel(R) Centrino(R) WiMAX 6150 Intel(R) Centrino(R) WiMAX 6150 Intel(R) Centrino(R) WiMAX 6150 Intel(R) Centrino(R) Wimiport Adapter Microsoft Virtual WiFi Miniport Adapter #2

Сүлжээний картын интернэт хаягийн тохиргоо хийх

- ✓ *Start* цэсийн *Control Panel* товчийг сонгосноор системийн тохиргоо хийх цонх гарна.
- Network and Sharing Center сонгох ба түүний дараа цонхны зүүн хэсэгт байрлах Change adapter settings холбоосыг дар.



 Та компьютерт сүлжээний кабелийг залгасны дараа зураг дараах байдалтай болж өөрчлөгдөнө.





Ашиглаж байгаа сүлжээний карт дээр хулганын баруун товчийг дарж, гарах цэсээс *Properties* сонголтыг сонгоно.

Бидэнд зөвхөн Internet Protocol Version 4 (TCP/IPv4) сонголт л шаардлагатай. Түүнийг сонгоод Properties товч дээр дарна. Гарч ирэх цонхноос сүлжээний тохиргоо хийгдсэн эсэхийг шалгах, мөн тохируулах боломжтой.



Networking Sharing Connect using:	Local Area Connection Properties	X
Connect using: Intel(R) Centrino(R) WIMAX 6150 Configure This connection uses the following items: Cilent for Microsoft Networks Cilent for Microso	Networking Sharing	
Intel(R) Centrino(R) WiMAX 6150 Configure This connection uses the following items: Cient for Microsoft Networks	Connect using:	
Configure This connection uses the following items: Client for Microsoft Networks Qo S Packet Scheduler Qo S Packet Scheduler File and Printer Sharing for Microsoft Networks Intermet Protocol Version 6 (TCP/IPv6) Internet Protocol Version 6 (TCP/IPv4) Ink-Layer Topology Discovery Mapper I/O Driver Ink-Layer Topology Discovery Responder Install Uninstall Properties Description Transmission Control Protocol/Internet Protocol. The default wide area network protocol that provides communication across diverse interconnected networks. OK Cancel OK Cancel OK Cancel	Intel(R) Centrino(R) WiMAX 6150	
This connection uses the following items:		Configure
Client for Microsoft Networks QoS Packet Scheduler GoS Packet Scheduler File and Printer Sharing for Microsoft Networks Intermet Protocol Version 6 (TCP/IPv6) Intermet Protocol Version 4 (TCP/IPv4) Intermet	This connection uses the following items:	
✓	Client for Microsoft Networks	
	QoS Packet Scheduler	.
	File and Printer Sharing for Microsoft Netwo	rks
	Internet Protocol Version 6 (TCP/IPv6)	
	Internet Protocol Version 4 (TCP/IPv4)	Dia
Install Uninstall Properties Description Transmission Control Protocol/Internet Protocol. The default wide area network protocol that provides communication across diverse interconnected networks. OK Cancel	Link-Layer Topology Discovery Mapper I/O	Driver
Install Uninstall Properties Description Transmission Control Protocol/Internet Protocol. The default wide area network protocol that provides communication across diverse interconnected networks. OK Cancel	Ink-Layer Topology Discovery Responder	
Install Uninstall Properties Description Transmission Control Protocol/Internet Protocol. The default wide area network protocol that provides communication across diverse interconnected networks. OK Cancel		
Description Transmission Control Protocol/Internet Protocol. The default wide area network protocol that provides communication across diverse interconnected networks. OK Cancel	Install Uninstall	Properties
Transmission Control Protocol/Internet Protocol. The default wide area network protocol that provides communication across diverse interconnected networks.		
wide area network protocol that provides communication across diverse interconnected networks.	Transmission Control Protocol/Internet Protocol. T	he default
across diverse interconnected networks. OK Cancel	wide area network protocol that provides commun	nication
OK Cancel	across diverse interconnected networks.	
OK Cancel		
OK Cancel		
	ОК	Cancel

✓ Ta IP address, Subnet mask, DNS server address зэргийг бичсэний дараа ОК товчийг дарж тохиргоог хадгална.

eneral					
You can get If this capability for the approp	P settings assigned . Otherwise, you r priate IP settings.	d automatica need to ask	Illy if your ne your network	twork sup administr	ports ator
) <u>O</u> btain a	n IP address auto	matically			
O Use the	following IP addre	SS:			
IP address:	:	20	3.212.28	. 99	
S <u>u</u> bnet mas	sk:	25	5 . 255 . 25	5.240	
<u>D</u> efault gat	eway:	20	3.212.28	. 97	
🔘 O <u>b</u> tain D	NS server addres	s automatica	lly		
OUse the	following DNS serv	ver addresse	s:		
Preferred D	NS server:	20	3.212.28	. 85	
<u>A</u> lternate D	NS server:	18	0.149.64	. 10	
🔲 Vaļidate	settings upon exi	t	[Ad <u>v</u> anc	ed
			ОК		Cancel

Файл болон хавтсыг хамтарч ашиглах тохиргоо хийх

- ✓ Start цэсийн Control Panel товчийг сонгосноор системийн тохиргоо хийх цонх гарна.
- ✓ Network and Sharing Center сонго. Гарах цонхны зүүн хэсэгт байрлах Home Group холбоосыг дар. Түүний дараа Change advanced sharing center холбоосыг сонго.



✓ Та энэ хэсэгт өөрийн ашиглах дотоод сүлжээндээ зориулж тохируулга хийнэ.

Эдгээр 🛛 🕙 🔿 товчнууд дээр дарснаар та дараах 2 сонголтын аль нэг рүү орно.

- о Home or Work Гэртээ эсвэл ажил дээр
- о Public Нийтийн

Та дээрх 2 сонголт тус бүрийн хувьд өөрийн компьютер дээрх файл, хавтас, хэвлэх төхөөрөмж зэргийг тухайн сүлжээндээ бусадтай хамтран ашиглах эсэхийг шийдэх сонголтуудыг хийх боломжтой.

Дараах зурганд харуулсан шиг Network Discovery, File and Printer, Public Folder Sharing хэсгүүд дэх сонголтыг ON, харин Password Protected Sharing хэсэг дэх сонголтыг OFF болгож, **Save changes** товчийг дар.


Хамтран ашиглах файл болон хавтсыг зааж өгөх

Дээрх бүх тохиргоонуудыг хийсэн бол одоо дотоод сүлжээнд хамтран ашиглах файл болон хавтсыг зааж өгье. Үүнийг хийх дараах 2 арга байдаг.

- Public нэртэй хавтсыг ашиглах. Энэ нь анхнаасаа хамтран ашиглагдахаар тохируулагдсан байдаг. Та хүссэн файл болон хавтсыг Public хавтсанд хуулснаар түүнийг сүлжээн дэх бусад хэрэглэгчид ашиглах боломжтой болно. Public хавтсанд хандахын тулд дараах дарааллын дагуу хийнэ үү.
 - ✓ Windows Explorer цонхыг нээж, С диск дээр байрлах Users хавтас руу орсноор Public хавтсыг та олж харна.
- 2. Өөрийн хүссэн хавтсыг хамтран ашиглахаар тохируулах.
 - Хамтран ашиглахыг хүссэн файл эсвэл хавтсан дээр хулганын баруун товчийг дарж, гарах цэсээс *Properties* командыг сонгоно.
 - ✓ Sharing табыг сонгож, Advanced Sharing товчийг дар.
 - ✓ Share this folder -ийг сонгоно.

Advanced Sharing
share this folder
Settings
Share name:
Уран зохиол 🔻
Add Remove
Limit the number of simultaneous users to: 20
Comments:
Permissions
OK Cancel Apply



✓ Permissions товч дээр дарснаар сүлжээн дэх ямар хэрэглэгчид тухайн файл, эсвэл хавстыг хэрхэн хэрэглэх талаар тохируулах харилцах цонх гарна. *Group or user names* хэсэгт тухайн файл эсвэл хавтсыг хамтран хэрэглэх сүлжээн дэх бусад хэрэглэгчдийн нэрс байна. *Add* товч дээр дарж хэрэглэгчдийг нэмэх боломжтой.

Permissions for Everyone хэсэгт байрлах сонголтуудыг доор тайлбарласан байна.

- Full Conrtol: файл/хавтсыг эсвэл түүний агуулгыг унших, өөрчлөх болон устгах бүх зөвшөөрөл
- Change: файл/хавтсыг эсвэл түүний агуулгыг унших, өөрчлөх зөвшөөрөл
- *Read:* файл/хавтсыг эсвэл түүний агуулгыг зөвхөн унших зөвшөөрөл

Та дээрх сонголтуудыг сүлжээн дэх бүх хэрэглэгчдэд ижил, эсвэл хэрэглэгч бүрийн хувьд ялгаатай байдлаар тохируулж болно. Үүний тулд *Group or user names* хэсгээс хэрэглэгчийг сонгож, дээрх зөвшөөрлүүдийг

Permissions for Уран зохио	л	×
Share Permissions		
Group or user names:		
Street Everyone		
L	Add	Remove
Permissions for Evenyone	Allow	Denv
Full Control		
Change		
Read		
Learn about access control and	permissions	
ОК	Cancel	Apply

олгохыг хүсвэл *Allow,* эсрэг тохиолдолд *Deny* баганад байрлах харгалзах нүдийг тэмдэглэх хэрэгтэй.

- ✓ Тохируулгыг хийж дуусаад **ОК** товчийг дарна.
- ✓ **Close** товчийг дарж, тохиргоог дуусгана.

Хамтарч ашиглах тохиргоо хийгдсэн файлыг харах

- ✓ Windows Explorer цонхыг нээнэ.
- ✓ Network-н зүүн талд байрлах суман дээр дарах үед сүлжээнд байгаа компьютерүүдийн нэрс гарч ирнэ.
- ✓ Холбогдохыг хүссэн компьютерийн нэр дээр дарахад, хамтран хэрэглэхээр тохируулагдсан файл болон хавтсууд цонхны баруун талд гарч ирнэ.

🖻 🝓 Homegroup	Image: Search ZOL00-HP Image: Search ZOL00-HP
⊿ p Computer ▷ 🏭 Local Disk (C:) ▷ 📻 Data (D:)	Organize ▼ Network and Sharing Center >
 ✓ Network ▷ IN E2UA-PC ▷ IN SARAA-HP 	2 items

Файл шахах/задлах

Файл шахах үйлдэл нь өгөгдлийн хэмжээг байж болох хамгийн бага түвшинд хүргэх процесс юм. Шахагдсан файлууд ихэвчлэн .<u>ZIP</u> буюу <u>.RAR</u> өргөтгөлтэй байдаг. Шахагдсан файл буюу хавтсыг буцааж задлахад шахах/задлах WinZip, WinRar гэх мэтийн програм хэрэгтэй. Гэхдээ Windows үйлдлийн систем өөртөө энэ програмыг агуулж байдаг.

Windows үйлдлийн системийн өөрийн шахагчийг ашиглан файл шахахдаа:

- 1. Шахах файл буюу хавтсыг хулганын зүүн товчийг товшин сонгоно.
- 2. Гарч ирэх цэсээс Send to»Compressed(zipped) folder командыг сонгоход файл буюу хавтасны нэртэй ижил нэр бүхий шахагдсан файл үүснэ.

😋 🔍 🔻 🕨 Computer 🔸 Local Di	sk (E:) → Hicheeluud →	•	Search Hic ₽
Organize 🔻 湇 Open Include	in library 🔻 Share with 💌 Burn	New folder	:= - 1 🔞
Introduction Name Nyam	Open Open in new window	ified Type 10:17 AM File folder	Size
Dento Dento Dento	Open as Notebook in OneNote	9:39 PM File folder	
↓ SOI-2012May ↓ IT10 ♥ Nyam ↓ IT20 ▲ ajlaaas ↓ IT20 ↓ ajlaaas ↓ IT20 ↓ ajlaaas ↓ IT20 ↓ book folder ↓ IT20 ↓ c-ees ↓ JIT3 ↓ FEcourse ↓ vogv ↓ FLASH HICH ₩ 2010	7-Zip Share with Groove Folder Synchronization Restore previous versions Include in library Add to archive Add to "IS302.rar" Compress and email Compress to "IS302.rar" and email	 10:53 PM File folder 8:14 PM File folder 2:43 PM File folder 2:08 PM File folder 8:15 PM File folder 11:24 PM File folder 9:46 AM File folder 8:15 PM File folder 3:57 PM Microsoft Office 	69 KB
ICDL	Send to	Compressed (zipped) folder	806 KB
install Java lesson IS302 File folder	Cut Copy Create shortcut Delete Rename	 Desktop (create shortcut) Documents Fax recipient Mail recipient Skype DVD RW Drive (F:) 	048 KB 194 KB
New Picture	Properties	4 ▶	Zoom: 🔍

Шахагдсан файл буюу хавтсыг буцааж задлахын тулд:

- 1. Шахагдсан файл буюу хавтсыг хулганын зүүн товчоор товшин сонгоно.
- 2. Сонгосон файл буюу хавтас дээр хулганын баруун товчоор товшиход гарах командын цэсээс Extract Here командыг сонгоно.



Вирусны эсрэг програм

Компьютерийн вирус бол хэрэглэгчид мэдэгдэлгүйгээр өөрөө өөрийгөө хувилж тараадаг жижиг хэмжээний програм юм. Хэд хэдэн төрлийн вирус байдгаас зарим нь санах байгууламжууд дээрх өгөгдлийг устгах чадвартай байдаг. Вирус тархах замуудад:

- ✓ Компьютерт вирус бүхий диск холбох.
- ✓ Электрон захиагаар (и-мэйл) ирсэн вирусын файлыг нээх.
- ✓ Дотоод сүлжээгээр вирусээр халдварлагдсан файлыг хамтран ашиглах.

Антивирусын програмууд нь компьютерийг ихэнх мэдэгдэж буй вирусээс хамгаалдаг. Энэ програмууд ихэвчлэн компьютер дэх вирусыг илрүүлээд, халдварласан файлыг устгах буюу халдваргүйжүүлдэг. Хэрэглэгчид янз бүрийн антивирусын програм ашигладаг боловч антивирусын програмаар өөрийн компьютерийг шалгахдаа дараах ерөнхий алхмуудыг дагаж болно.

- 1. Start цэсийг дарна.
- 2. All Programs-ийг сонгоно.
- 3. Гарч ирэх програмуудын жагсаалтаас өөрийн антивирусын програмыг сонгоно.
- 4. Шалгах сонголтоо хийж, шалгалтыг эхлүүлнэ.

Харамсалтай нь шинэ вирусууд байнга гарч ирсээр байгаа учраас антивирусын програмыг үргэлж шинэчилж байхгүй бол уг програм шинэ вируснуудыг илрүүлэн, устгаж чадахгүй болдог. Ихэнх антивирусын програмууд интернэттэй орчинд автоматаар шинэчлэгддэг.

Microsoft Security Essentials програмын суулгах

Таны Windows үйлдлийн систем бүхий компьютерт хурдан, хөнгөхөн антивирусын шийдэл хэрэгтэй байна уу? Microsoft корпораци нь Windows үйлдлийн системийн бүх хэрэглэгчдэд зориулж үнэгүй ашиглах боломжтой антивирусын програмаар хангадаг. Та түүнийг хэдхэн минутад татаж авах болон суулгах боломжтой. Үүнийг хийхийн тулд та дараах алхмуудыг дагах хэрэгтэй.

- 1. Та <u>www.google.com</u> хайлтын вэб системийн хайлтын хэсэгт "**Misrosoft Security Essentials**" гэж бичиж өгнө.
- Хайлтын үр дүнд гарах Security Essentails вэб сайт руу хандаж, програмыг татаж авна. Security Essentails нь Windows үйлдлийн системийг вирусээс хамгаалах үнэгүй програм юм. Та тухайн агшинд зөвхөн нэг л антивирусын програмыг системдээ суулгах боломжтой гэдгийг анхаарна уу.
- 3. Таны вэб хөтчийн тохируулгаас шалтгаалан уг файлыг татаж авахын өмнө та түүнийг зөвшөөрөх хэрэгтэй болж болох юм. Windows 8 үйлдлийн системд урьдчилаад Security Essentails програм нь суулгагдсан байдаг тул хэрэв та Windows 8 үйдлийн систем дээр ажиллаж байгаа бол Download товч идэвхгүй байна.
- 4. Файл татагдаж дууссаны дараа түүнийг ажиллуулж, програмыг өөрийн компьютерт суулгаснаар таны компьютер бүрэн хамгаалагдах болно.

Хэвлэх төхөөрөмж ашиглах

Хэрэглэгч ямар нэг мэдээлэл хэвлэхийн тулд тодорхой нэг хэвлэгч төхөөрөмжийг зааж, хэвлэх мэдээллээ тухайн хэвлэгч рүү илгээх ёстой болдог. Хэрэв анхдагч хэвлэгчийг тодорхойлж өгвөл хэвлэх команд өгөхөд шууд анхдагч хэвлэгч автоматаар сонгогддог. Хэрэглэгчийн хувьд анхдагч хэвлэгчээр зөвхөн нэг л хэвлэгчийг тодорхойлж болдог.

Хэвлэгчийг анхдагчаар тодорхойлохдоо:

2. Жагсаалтаас Devices and Printers командыг

1. **Start** товчийг дарна.

Devices and Printers

сонгоно.

- 3. **Devices and Printers** цонх гарч ирнэ. Энэ цонхонд уг компьютерт холбоотой байгаа хэвлэгч төхөөрөмжүүдийн жагсаалт харагдана.
- 4. Жагсаалтаас анхдагчаар тохируулах хэвлэгчээ сонгоод хулганын баруун товчийг товшиход командын цэс гарч ирнэ.

5. Командын цэсээс Set as Default Printer командыг сонгоно. Сонгогдсон хэвлэгчийн дүрслэл чагтаар тэмдэглэгдсэн байх ёстой.



Шинээр хэвлэх төхөөрөмийг таниулах

- ✓ Start товчийг дарна.
- ✓ Жагсаалтаас Devices and Printers командыг сонгоно.
- Devices and Printers цонх гарч ирнэ. Энэ цонхонд уг компьютерт холбоотой байгаа хэвлэгч төхөөрөмжүүдийн жагсаалт харагдана.
- ✓ Хэрэгслийн мөрнөөс Add a printer командыг сонгосноор Add Printer Wizard ажиллаж эхэлнэ.
- Хэвлэгчийн төрлөө сонгоод Next товчийг дарна.
- Дараагийн цонхнуудаас тохирох сонголтуудыг сонгоно.



интернэт хэрэглээ

ИНТЕРНЭТ

Хүн төрөлхтөний түүхэн дэх агуу ололтуудын нэг нь интернэт юм.

Интернэт гэдэг нь дэлхий даяарх мянга, мянган компьютерийн сүлжээг нэгтгэсэн асар том сүлжээ, сүлжээний дэд бүтэц юм.

2015 оны 8 сарын байдлаар 190 гаруй орны 3,1 тэрбум интернэт хэрэглэгч байна гэж ILS (Internet Live Stats) байгууллагаас тоо баримт гаргажээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны тайлангаар 2014 оны байдлаар Монгол улсын интернэт хэрэглэгчдийн тоо 1,962,100 байна.

Интернэт нь бидний өдөр тутмын амьдралд олон янзаар ашиглагдаж байна. Жишээбэл харилцаа холбоо, бизнесийн үйл ажиллагаа, төлбөр тооцоо, мэдээ унших, суралцах, эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт.

ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

Интернэт сүлжээг ашиглахын тулд юуны түрүүнд энэ сүлжээнд холбогдох хэрэгтэй. Интернэтэд холбогдох, ашиглах үйлчилгээг Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага (Internet Service Provider - АйЭсПи)-уудаар дамжуулан авна.



Та интернэтэд холбогдохын тулд мэдээлэл солилцох компьютер, гар утас болон бусад төхөөрөмжтэй байхаас гадна *интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгуулаг*аас үйлчилгээний эрх авах шаардлагатай.

Уг байгууллага нь таныг телефон утасны шугам, тусгай өндөр хурдны тоон шугам эсвэл гар утасны сүлжээгээр интернэтэд холбогдох боломжийг олгоно. Манай улсын хөдөө орон нутагт Мэдээлэл, Холбооны Сүлжээ ХХК болон гар утасны оператор компаниуд интернэтийн үйлчилгээг үзүүлж байна.

ISP байгууллагаар дамжуулан интернэтийн үйлчилгээ авахаас гадна Wi-Fi (ВайФай) холболтын бүсүүдийг ашиглан нийтийн интернэт үйлчилгээг авах боломжтой.

Wi-Fi холболтын бүсүүд хаана байдаг вэ?

Wi-Fi холболтын бүсүүд янз бүрийн газарт байна. Кафе, сургууль, оффис, автобусны буудал гэх мэт хүмүүс өөр зүйл хийж байхдаа ч ажлаа амжуулж болох газруудад түгээмэл тааралддаг. Эдгээр цэгүүдийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

- ✓ Төлбөртэй холболтын бүс: Ийм холболтын бүс нь эзэмшигчээсээ хамааран тодорхой төлбөр төлсөн тохиолдолд ашиглаж болохоор зохион байгуулагдсан байдаг ба нууц үгээр хамгаалагдсан байна.
- ✓ Төлбөргүй холболтын бүс: Зарим холболтын бүсүүд ашиглахад ямар нэг төлбөргүй, нийтэд нээлттэй байдаг.
- ✓ Хувийн холболтын бүс: Зарим хүмүүс утасгүй сүлжээний төхөөрөмж ашиглан өөрсдийн хувийн бүсийг үүсгэн ашигладаг. Энэ тохиолдолд нууц үгээр хамгаалагдсан байна.

Wi-Fi бүсэд хэрхэн холбогдох вэ?

Ихэнх зөөврийн компьютерүүдэд утасгүйгээр интернэтэд холбогдох боломж олгодог сүлжээний төхөөрөмжүүдийг суулгасан байдаг. *Windows* 7 үйлдлийн систем нь энэ төхөөрөмж байгаа тохиолдолд Wi-Fi холболтын бүсэд холбогдох үйл ажиллагааг маш энгийнээр шийдэж өгсөн байдаг. Ингээд хэрхэн холбогдох талаар авч үзье.

1. Task bar-н баруун хэсэгт байрлах утасгүй сүлжээний дүрс дээр дарна.

MN	8		al	Ô	als.		8:03 PM
	<u> </u>	9				<u> </u>	2014/7/30

- 2. Холбогдох боломжтой бүх Wi-Fi бүсийн жагсаалт гарч ирэхэд, өөрийн холбогдох бүсийг сонгон *Connect* товчийг дарна.
- Хэрэв таны холбогдох бүс нээлттэй бүс бол энэ үйдлийн дараа шууд холбогдоно. Харин нууцлалтай бүс бол нууц үг асуух цонх гарна. Энэ нууц үгийг интернэт үйлчилгээ үзүүлэгч компани танд олгох ёстой. Уг цонхонд нууц үгээ бичиж, ОК товч дарахад та тухайн бүсэд холбогдоно.
- 4. Харин одоо вэб хөтчөө ачаалан, интернэтээр аялахад бэлэн боллоо.

al	•
all	
all	
<u>C</u> onnect	1
	میں اور

work	x
ork security key	
Hide characters	
You can also connect by pushing the button on the router.	
	•
	work rk security key Hide characters You can also connect by pushing the button on the router. K

ИНТЕРНЭТИЙН ХУРД

Интернэт сүлжээний хүчин чадал нь сүлжээгээр дамжигдах өгөгдлийн хэмжээгээр тодорхойлогдох бөгөөд үүнийг *интернэтийн хурд* гэж нэрлэдэг. Интернэт сүлжээний хурдыг секундэд дамжигдах өгөгдлийн хэмжээгээр хэмжих ба *bps (bit per second), Kbps (kilo bps), Mbps (Mega bps)* гэж тэмдэглэдэг.

Видео бичлэг болон их хэмжээтэй зураг, файл зэрэг нь интернэтийн хурдаас хамааран удаан татагдах, гацах, тасалдах магадлалтай байдаг. Тиймээс интернэт хэрэглээнийхээ шаардлага, үйлчилгээний үнэ тарифаас хамааруулан ISP байгууллагаас өөрт тохирсон хурдтай интернэтийн үйлчилгээг авах хэрэгтэй.

Интернэтэд холбогдсоныхоо дараа сүлжээнийхээ хурдыг өөрөө шалгах боломжтой. Үүний тулд дараах алхмуудыг хийнэ.

- Та өөрийн хэрэглэдэг вэб хөтчийг нээнэ.
- Вэб хөтчийнхөө хаягийн хэсэгт <u>http://www.speedtest.net/</u> гэж бичээд Enter товчийг дарснаар дараах вэб сайттай холбогдоно.
- 3. **BEGIN TEST** товчийг дарж, интернэтийн хурдаа шалгах процессыг эхлүүлнэ.





 Шалгах процесс дууссаны дараа үр дүнг дэлгэцэнд дараах байдлаар харуулна. Энд, хэрэглэгчийн интернэтийн татах хурд 9.74Мбит/с, илгээх хурд 1.97Мбит/с байна. Интернэтийн хурдыг шалгахдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- ✓ Интернэтийн хурдаа шалгахдаа интернэт хэрэглэж байгаа програмуудаа зогсоох эсвэл хаах. Жишээ нь: мэдээ унших, онлайн сургалт хүлээн авах, youtube.com-оос видео бичлэг үзэх гэх мэт.
- ✓ Үйлдлийн систем, вирусны эсрэг програм болон бусад автоматаар шинэчлэл хийдэг програмууд шинэчлэлээ хийж байгаа эсэхийг шалгах. Хэрэв шинэчлэл хийж байгаа бол зогсоох, эсвэл уг процесс дууссаны дараа интернэтийн хурдаа шалгах.
- ✓ Та интернэтийн холболтоо ганцаараа ашиглаж байгаа эсэхээ шалгах. Хэрэв та интернэт холболтоо хэн нэгэнтэй хувааж хэрэглэдэг бол интернэтийн хурдны шалгалтын үр дүн багасч гарахыг анхаарна уу.

ДЭЛХИЙ ДАХИНЫ СҮЛЖЭЭ - WORLD WIDE WEB (WWW)

Интернэтийг ашиглах явцад World Wide Web (үгчилж орчуулбал дэлхий дахиныг холбогч) гэсэн нэр томъёо хэрэглэгддэг. Үүнийг бид товчлон вэб гэж хэлдэг. Энгийнээр тайлбарлавал вэб (WWW) гэдэг нь интернэт сүлжээгээр дамжих өгөгдлийг харуулах, хадгалах загвар юм.



ВЭБ САЙТ

Вэб сайт гэдэг нь интернэтэд байрлах сервер компьютерт хадгалагдсан өөрийн гэсэн хаягтай бүлэг өгөгдөл, програмыг хэлнэ.

Вэб сайт руу вэб сайтын хаягийг бичиж интернэт ашиглан хандана. Вэб сайтын хаягаар гарч ирэх мэдээллийг home page буюу нүүр хуудас гэж нэрлэдэг. Вэб сайт нь олон тооны вэб хуудаснаас бүрдэнэ.

2015 оны байдлаар дэлхий дээр 983,8 сая гаруй вэб сайтууд ажиллаж байна.

Жишээ нь: Google компанийн вэб сайтаас мэдээлэл болон програм хангамжуудыг татаж авахаас гадна хэрэглэгчид болон бизнесийн үйл ажиллагаанд зориулагдсан олон тооны үйлчилгээнүүдийг авах боломжтой.

URL (UNIFORM RESOURCE LOCATOR) XA9

URL (Uniform Resource Locator) хаяг гэдэг нь вэб сайтын хаягийг илэрхийлэх бичлэг бөгөөд дараах хэлбэртэй бичигдэнэ.

http://www.вэб_сайтын_нэр.өргөтгөл

http – Hyper Text Transfer Protocol буюу цахим мэдээллийг дамжуулах протокол
 www – дэлхий дахины сүлжээ
 вэб_сайтын_нэр – тухайн вэб сайтын нэр
 өргөтгөл – тус сайт ямар зориулалттай, аль улсынх гэдгийг тодорхойлдог.

Өргөн хэрэглэгддэг өргөтгөлүүд:

com – худалдааны сурталчилгааны сайт буюу ашиг орлогын төлөө үйл ажиллагаа явуулах сайт

edu – боловсролын сайт

доv – төрийн байгууллагын сайт

org – төрийн бус байгууллагын сайт

Мөн ихэнх URL хаягийн өргөтгөлд тухайн улсын нэрний товчлол орсон байдаг. Тухайлбал:

mn – Монгол улсын сайт

јр – Япон улсын сайт

ик – Их Британийн сайт

ru – Оросын холбооны улсын сайт

сп – БНХАУ-ын сайт гэх мэт.

Монголчуудын өргөн ашигладаг мэдээ, мэдээллийн вэб сайтуудын хаяг:

http://www.news.mn/ - Монголын үндэсний мэдээний сайт http://www.must.edu.mn/ - Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн сайт http://www.ncsc.gov.mn/ - Монголын Кибер Аюулгүй Байдлын Газар https://www.coursera.org/ - Дэлхийн нэр хүндтэй их, дээд сургуулиудыг нэгтгэсэн онлайн сургалтын сайт

вэб хөтөч

Вэб хөтөч нь интернэт сүлжээн дэх вэб хуудсуудыг хайх, харах, өгөгдөл дамжуулах боломжийг агуулсан програм хангамж юм.

2015 оны байдлаар хамгийн өргөн ашиглагдаж байгаа вэб хөтчүүдийг жагсаавал:

- "Google Chrome" 🧐
- "Mozilla Firefox" 🔩
- "Internet Explorer" 🨂
- "Apple Safari" 📎
- "Opera" **O**

Эдгээр програмууд нь тус бүрдээ олон ялгаатай хувилбаруудтай байдаг. Сүүлийн хувилбарууд нь өмнөх хувилбараа сайжруулсан байх ба ашиглалтын уян хатан нөхцөл болон өвөрмөц шинж чанаруудыг санал болгодог.

Таны компьютер, гар утас, төхөөрөмж интернэтэд холбогдсон ч вэб хөтөч програмыг ашиглахгүйгээр мэдээллийг харах, илгээх боломжгүй.

Жишээ болгон "Google Chrome" вэб хөтчийг танилцуулъя.

GOOGLE CHROME

Google Chrome вэб хөтчийг ажиллуулах

- ✓ Хэрэв таны компьютерт **Google Chrome** програм суугаагүй бол шинээр суулгана.
- ✓ Үүний тулд таны компьютерт суусан вэб хөтөч програмыг ашиглан <u>http://www.google.com/chrome/</u> сайт руу орж *Download* хэсгээс програмыг татан авч, компьютертээ суулгана.
- ✓ Програмыг суулгасны дараа Google Chrome icon нь ихэвчлэн дэлгэцийн зүүн доод булангийн хэсэгт харагдана.





- Мөн ихэнх компьютерийн дэлгэцэн дээр Google Chrome icon байрласан байдаг.
- Google Chrome вэб хөтчийг ажиллуулахын тулд дээр тайлбарласны дагуу хоёр *icon*-ы аль нэг дээр дарна.
- Google Chrome хөтөч нээгдэх үед Home Page дуудагдана. Та вэб хөтчийг нээх бүрт ямар вэб хуудас уг цонхон дээр гарах нь Home Page-ээр тохируулагдсан байдаг.

Google x								
← → C A https://www.gor	a gle.mn /?gws.rd=cr.ssl&ei=eVG8	/f6rKcyx0AS_7JUBw						=
			Battoetseg	Gmail	Images	ш	0	•
	Go	ogle	lla					
	Geogle Search	I'm Feeling Lacky		Ŷ				
	Google me	effered in: Mowran						
Advertising Business Abc	ut		Privacy 1	'erns	Settings	Use	Google	.com

Вэб сайтны хаягийг оруулах

Google Chrome цонхны дээд хэсэгт хаягийн хэсэг байрладаг. Хаягийн хэсэг дээр вэб сайтын хаягийг бичиж өгнө. Жишээ нь Microsoft корпорацийн вэб хаягийг (*www.microsoft.com*) бичиж, Enter дарахад Microsoft корпорацийн вэб хуудас таны хөтөч дээр гарна.



Цахим холбоос – Hyperlink

✓ Та дэлгэцэнд дүрслэгдсэн вэб хуудсан дээгүүр хулганы заагчийг зарим текст эсвэл зурган дээр байрлуулахад дараах гарны зураг бүхий хэлбэрт орж өөрчлөгдөнө.



- ✓ Хэрэв хулганы заагчийн хэлбэр дээрх байдлаар өөрчлөгдсөн бол та цахим холбоос дээр хулганы заагчийг байрлуулсан гэсэн үг юм. Цахим холбоос дээр дарах үед дараах зүйлс хийгдэнэ. Үүнд:
 - Тухайн вэб хуудасны өөр хэсэг рүү шилжих
 - Уг вэб сайтын өөр хуудас руу шилжих
 - Өөр вэб сайтын хуудас руу шилжих
 - Файл татаж авах боломжтой болох
 - о Програм, видео, дуу бичлэг ажиллуулах

Вэб хуудасны хэмжээг тохируулах

- ✓ Вэб хуудасны текстийн харагдах хэмжээг өөрчлөхдөө *Ctrl* товч болон + (нэмэх) эсвэл – (xacax) товчнуудын хослолыг ашиглана. Мөн *Ctrl* товч болон хулганы дундах товчны эргэлтээр томруулж эсвэл багасгаж болно.
- ✓ Ctrl + 0 товчнуудын хослолыг дарж текстийн хэмжээг хэвийн хэмжээнд нь буцаан оруулна.

Өмнөх болон дараагийн хуудас руу шилжих

Вэб хөтчийн дэлгэцэн дээр харуулсан өмнөх хуудас руу шилжих, өмнөх хуудаснаас буцах боломжтой.

Дэлгэцэн дээр харагдаж буй хуудасны өмнө зочилсон хуудас руу шилжихэд **Back** (зүүн тийш заасан сум) товчийг хулганаар дарна. Эсвэл **Alt +** (зүүн тийш сум) товчнуудын хослолыг дарж болно.

Back үйлдлийг буцаахыг хүсвэл **Forward** (баруун тийш заасан сум) товчийг хулганаар дарна. Эсвэл **Alt +** (**баруун тийш сум**) товчнуудын хослолыг дарж болно.

Эдгээр товчнууд нь хаягийн хэсгийн урд байрлана.



Шинэ хуудсанд вэб хуудсыг харуулах

Та цахим холбоос дээр дарахад гарах хуудсыг шинээр хуудас үүсгэн, түүн дээрээ гаргахыг хүсвэл цахим холбоос дээр хулганыг байрлуулж баруун товчийг дарна. Гарах жагсаалтаас **Open link in new tab** командыг сонгоно.



Дээрх жишээнд "Хакүхо аваргын наадам" гэсэн мэдээг шинэ хуудас нээн дэлгэцэнд харуулав. Ингэснээр дэлгэцэнд дахин нэг хуудас нээгдсэн нь доорх зургаас харагдаж байна.

M M	оогол -	Үндэсний хайл 🗙 🗸 👩 www.news.mn Мэдээлли 🗙	🙆 Хакүхо аваргын наадам	×
$\langle - \rangle$	G	sport.news.mn/content/218689.shtml		

Нээлттэй хуудас хооронд шилжих

- ✓ Нэг хуудаснаас нөгөө рүү шилжихдээ тухайн шилжихийг хүссэн хуудас дээрээ очин хулганы зүүн товчоор нэг дарна.
- ✓ Үүнээс гадна *Ctrl+Tab* товчны хослолоор хуудас хооронд шилжих боломжтой.

Хуудсыг хаах

Google Chrome дахь нээлттэй хуудсыг хаахын тулд хуудас бүрийн баруун талд орших *Close* (чагтан дүрс) дээр дарна. Эсвэл *Ctrl+F4* товчны хослолоор хуудсыг хаана.

🥖 🧰 Моогол -	Үндэсний хайл 🗙	间 www.news.mn Мэдээлл	🗙 💿 Хакүхо аваргын наадам 🗙
$\leftrightarrow \rightarrow \mathbf{C}$	🗋 sport.news.r	nn/content/218689.shtm	

Stop товч

Та вэб хуудас ачаалагдаж байх үед түүнийг зогсоохыг хүсч болно. Энэ нь хуудас удаан ачаалагдах, вэб хуудсан дахь бүх зургууд дүрслэгдэхийг хүлээх шаардлагагүй зэрэг үед хэрэглэж болно.

Хуудас ачаалагдах явцыг зогсоохын тулд *Stop* товч дээр дарна.

Moc	огол -	Үндэсний хайл 🗙 🔍 , www.news.mn Мэдээлли 🗙 🔟 Хакүхо аваргын наадам 🛛 🗙 🗌	
$\leftarrow \ \Rightarrow$	×	sport.news.mn/home.shtml;jsessionid=0DE7584EAB3F0FDD74864450	

Вэб хуудсыг дахин ачаалах

Вэб хуудсыг нээснээс хойш хэсэг хугацаанд уг вэб хуудсанд шинэ мэдээллүүд нэмэгдсэн байх боломжтой. Тэгвэл энэ тохиолдолд хуудсыг хаагаад, дахин нээх биш, зөвхөн тухайн хуудсаа дахин ачаалахад л хангалттай.

Хуудсыг дахин ачаалахын тулд *Refresh* дүрсэн дээр хулганаар дарна. Эсвэл **F5** товчийг дарна.

Mo 📶	огол -	Үндэсний хайл 🗙 💿 www.news.mn Мэдээлли 🗴 💿 Хакүхо аваргын наадам 🛛 🗙 📋
← ⇒	G	sport.news.mn/home.shtml;jsessionid=0DE7584EAB3F0FDD74864450

Вэб хуудаснаас файл татах

Зарим вэб хуудаснуудад файл татах боломжтой цахим холбоос байх ба файл нь ямар нэг баримт эсвэл програм байж болно. Та цахим холбоос дээр дарснаар уг файл таны компьютерт татагдана. Жишээ болгон ЭЕШ-нд бэлтгэгчдэд зориулсан жишиг даалгаврыг татаж авцгаая. Үүний тулд дараах алхмуудыг хийнэ.

✓ ЕБС-ийн Боловсролын үнэлгээний төвийн ЭЕШ-ын жишиг даалгаврууд тавигдсан вэб сайт <u>http://www.eec.mn/page/109/39</u> руу хандана.

A A A A A A A A A A A A A A A A A A A				
Б.Ү.Төв - ЭЕШ-ЫН ЖИШИ ×				
$\leftarrow \rightarrow \mathbf{C}$ \square www.eec.mn/page/109/39				
ЭЕШ 2015 СУУДЛЫН ХУВААРИА ЭНД ДАРЖ ХЭВЛЭН АВНА УУ.				
НҮҮР ХУУДАС МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ БИДНИЙ ТУХАЙ ЭЕШ ГОСШ ҮНЭЛГЭЭ ХОЛБОО БАРИХ АРХИВ				
▶ Б.Ү.Төв - ЭЕШ-ЫН ЖИШИГ ДААЛГАВАР - ЭЕШ-ЫН ЖИШИГ ДААЛГАВАР				
Share with mixx.mn Tweet 5 FLike Share 476				
2012 оны Элсэлтийн Ерөнхий Шалгалтанд бэлтгэгчдэд зориулсан жишиг даалгаврууд тавигдлаа.				
1. Математикийн хичээлийн жишиг даалгавар ЭНД ДАРЖ гатаж авна уу. ЗӨВ ХАРИУ				
2. Монгол хэлний хичээлийн жишиг даалгавар ЭНД ДАРЖ татаж авна уу.				
3. Физик ийн хичээлийн жишиг даалгавар ЭНД ДАРЖ татаж авна уу. ЗӨВ ХАРИУ				
4. Англи хэлний хичээлийн жишиг даалгавар ЭНД ДАРЖ татаж авна уу. ЗӨВ ХАРИУ				
5. Хими йн хичээлийн жишиг даалгавар ЭНД ДАРЖ татаж авна уу. ЗӨВ ХАРИУ				
6. Нийгмийн тухай мэдлэг хичээлийн жишиг даалгавар ЭНД ДАРЖ татаж авна уу. ЗӨВ ХАРИУ				
7. Орос хэлний хичээлийн жишиг даалгавар ЭНД ДАРЖ татаж авна уу. ЗӨВ ХАРИУ				
8. Монгол улсын түүх хичээлийн жишиг даалгавар ЭНД ДАРЖ татаж авна уу. ЗӨВ ХАРИУ				
9. Биологийн хичээлийн жишиг даалгавар ЭНД ДАРЖ татаж авна уу. ЗӨВ ХАРИУ				
10.Газарзүйн хичээлийн жишиг даалгавар ЭНД ДАРЖ татаж авна уу. ЗӨВ ХАРИУ				
ЭЕШ-ЫН ХАРИУЛТЫН ХУУДАС БӨГЛӨХ ЗААВАР, ЗӨВЛӨМЖ ЭНДЭЭС ТАТАЖ АВНА УУ.				

✓ Матетатикийн хичээлийн жишиг даалгаврыг татаж авахын тулд 1-р мөрөнд бичигдсэн ЭНД ДАРЖ гэсэн үгэн дээр дарна.

Вэб хуудаснаас татсан файлыг нээх

Интернэтээс татсан файлаа нээхийн тулд дараах алхмуудыг хийнэ.

- Google Chrome вэб хөтчийн баруун дээд буланд байрлах тохиргооны товчийг дарж, Downloads командыг сонгоход интернэтээс татагдсан файлуудын жагсаалтыг гарна.
- Татагдсан файлуудын жагсаалт дараах байдлаар харагдана. Тухайн файлыг нээхийн тулд файлын нэрэн дээр дарна.



🕖 🗾 Б.Ү.Төв - ЭЕШ-ЫН ЖИЦ	J/ × Downloads ×	
$\leftarrow \rightarrow \mathbf{C}$ C chrom	e://downloads	
Downloads		
Today Aug 10, 2015	mat01.pdf http://www.eec.mn/uploads/file/jishig2012/mat01.pdf Show in folder Remove from list	— Файлын нэр

Show in folder товчийг дарж, тухайн файл таны компьютерт хаана хадгалагдсаныг харах боломжтой. Жишээнд, таны татсан mat01.pdf файл D:\Download хавтсанд хадгалагдсан байна.



Вэб хуудаснаас татах файлыг хадгалах хавтасны тохиргоо хийх

Та вэб хуудаснаас өөрт хэрэгцээт файлаа татаж аван компьютертээ хадгалахдаа бүх файлуудыг нэг хавтаст хадгалагдахаар, эсвэл файл бүрийг хаана хадгалахыг зааж байхаар тохируулж болно. Үүний тулд дараах алхмуудыг хийнэ. Үүнд:

- Google Chrome вэб хөтчийн баруун дээд буланд байрлах тохиргооны товчийг дарж, Settings командыг сонгон тохиргооны хуудсыг нээнэ.
- ✓ Settings хуудсан дахь Downloads хэсэгт анхаарлаа хандуулна уу.
- Download location-ий ард файл хадгалах хавтасны замыг бичиж өгч болно. Эсвэл Change товчийг дарж, хавтасны замыг зааж өгөх боломжтой. Жишээнд D:\Downloads хавтсыг зааж өгсөн байна. Энэ тохиолдолд таны интернэтээс татаж авсан бүх файлууд D:\Downloads дотор хадгалагдана.



 Downloads хэсгийн Ask where to save each file downloading тэмдэглэгээг тавьснаар файл бүрийг хадгалахдаа хаана хадгалахыг зааж өгнө.

Downloads		
Download location:	D:\Downloads	Change
Ask where to sa	ve each file before downloading	

ИНТЕРНЭТЭЭС МЭДЭЭЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ

Өнөөгийн "Мэдээллийн эрин" буюу мэдээлэлд хүрэх арга замыг хялбарчилж чадсан МХХТ-ийн шинэчлэл нь бидний аж амьдрал, ажил төрөл, амралт зугаалга гээд бүхий л үйл явдлын арга хэлбэрийг өөрчлөөд байгаа билээ. Үүний нэг жишээ нь Интернэт сүлжээ юм.

Интернэт нь асар их мэдээллийг өөртөө агуулдаг. Эдгээр мэдээлэл нь дэлхийн олон орнуудад байрлах вэб серверүүд дээр хадгалагдаж байдаг бөгөөд бид сонирхсон мэдээллээ тухайн мэдээллийг бидэнд харуулах вэб сайтаар нь дамжуулан авна. Интернэт сүлжээнээс мэдээлэл, үйлчилгээ авахдаа бид шууд хаягаар нь хандаж болно эсвэл хайлтын систем ашиглаж болно.

ШУУД ХАЯГААР НЬ ХАНДАН МЭДЭЭЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ

Энэ аргаар мэдээлэл авах гэж байгаа үед тухайн мэдээллийг агуулах вэб сайтын хаягийг мэдэх шаардлагатай. Тухайлбал дараах үйлчилгээнүүдийг авч болно.

Төрийн үйлчилгээ

Төр засаг нь хууль тогтоол, дүрэм журам, шийдвэр, зарлиг гаргаж тэдгээрийг хэрэгжүүлэх бүтэцтэй байдаг ба энэ нь үйл ажиллагааны гол гарц, үр дүн болдог.

Засгийн газар нь тогтвортой, ардчилсан засаглал, удирдлага сайтай төрийн байгууллагууд нь улс орны хөгжил, цэцэглэлтэнд ихээхэн ач холбогдолтой болохыг сайтар ойлгох болжээ. Гэхдээ сайн үйл ажиллагаатай, чадавхитай төр нь дангаараа төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээнд нийцтэл сайн хүргэж чадахгүй, харин өөрөө хариуцлагатай, иргэддээ эргэн тайлагнадаг байх ёстой хэмээн илүү ихээр үзэх болсон байна.

Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээнд МХХТ-ийг хэрэглэснээр Засгийн газрын үйл ажиллагааг нээлттэй, илүү үр дүнтэй, хэмнэлттэй болгохоос гадна төрөөс үзүүлэх үйлчилгээг үр дүнтэйгээр иргэдэд хүргэх боломжийг бүрдүүлж болно. Мөн засгийн газрын үйл ажиллагаа нээлттэй болсноор иргэдийн оролцоо нэмэгдэж, илүү хариуцлагатай, ардчилсан болох юм.

Монголын засгийн газраас иргэдэд үзүүлэх үйлчилгээнүүддээ МХХТ-ийн дэвшлийг хэрэглэж, зохих дэвшил гарсаар байна.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

Монгол улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болох <u>http://www.legalinfo.mn/</u> сайтнаас Монгол улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Монгол Улсын олон улсын гэрээ, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал зэрэг эрх зүйн мэдээллүүдийг авах боломжтой.



Иргэдийн санал хүлээн авах 11-11 төв

Монгол улсын Засгийн Газар иргэддээ нээлттэй, тунгалаг төрийг цогцлоохын тулд хүнд суртлыг халж, хурдан шуурхай үйлчилгээг эрхэмлэн иргэдийн санал хүсэлтийн хүлээн авч, тодорхой хариулт өгөхөөр "11-11 ТӨВ"-ийг байгуулсан. Тус төв нь иргэдээс ирэх санал хүсэлт, шүүмжлэл, гомдол, талархал нэг бүрийг утасны дуудлага болон мессеж, биечлэн, санал бичих машин-киоск, олон нийтийн сүлжээ, и-мэйл, вэб сайт зэрэг 10 сувгаар хүлээн авч, холбогдох байгууллагад шилжүүлэн түүний хяналт, хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгч байна. Та тус төвийн сайт <u>http://11-11.mn/</u> руу хандан санал өгөхийн тулд дараах алхмуудыг хийнэ. Үүнд:

✓ Вэб хөтчөө нээн <u>http://11-11.mn/</u> сайт руу хандана.
 Генилууд - "11 11 ТӨВ" × Ш Тенийн тухай - "11 11 ТС × Ц



- ✓ Вэб сайтны баруун дээд буланд байрлах **Санал оруулах** холбоос дээр дарна.
- Санал оруулахын тулд нэвтрэх шаардлагатай. Шинээр бүртгүүлэх холбоос дээр дарж бүртгэл үүсгэж болохоос гадна Facebook, Twitter олон нийтийн сүлжээний хаягаа ашиглан нэвтэрч, санал оруулах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР	1
1111 TOE	3
Нэвтрэх нэр эсвэл имэйл хаяг	
Нууц үг	
Нэвтрэх	
Нууц үгээ мартсан Шинээр бүрттүүлэх	_
f Facebook 🕑 Twitter	

💷 Миний саналууд - "11 11 🗙 📃		
← → C 🗋 11-11.mn/app/ti	ickets/#_=_ 🟠 🖬	:
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР	Санал хайх Q. 🏦 Ексеневая Ваttsetseg 🗎 Нууц уг солих 🔘 Өнгө 🔻 🏕 Гарах	Î
1111 TƏB	Миний саналууд 🔹 🗲	
🔒 Миний саналууд		
 Санал оруулах 	У Хаих Осанал байна	
🕑 Хариу ирсэн	Cysar byra Tepen byra Aimar xor byra T	
(3) Нээлттэй	2012-10-01 00:00	
🖌 Хаагдсан		
💼 Цуцлагдсан	Санал олдсонгуй.	
		Ŧ

Нийгмийн даатгалын үйлчилгээ

Монголын нийгмийн даатгалын газар нь даатгуулагч, ажил олгогч байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, нийгмийн даатгалын үйлчилгээг олон нийтэд шуурхай, ил тод, нээлттэй хүргэхийн тулд вэб сайт (<u>http://www.ndaatgal.mn/</u>)-аараа дамжуулан та бидний санал, зөвлөмжийг хүлээн авах, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэхийн сацуу иргэд, байгууллагуудад зориулсан хэд хэдэн үйлчилгээг хүргэж байна.

Тэдгээрийн нэг жишээ нь та энэ сайтнаас нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, нэрийн дансны мэдээллээ и-мэйлээр болон мессежээр хүлээн авах боломжтой. Үүний тулд дараах алхмуудыг хийнэ.

✓ Google Chrome вэб хөтчийн хаягийн хэсэгт Нийгмийн даатгалын ерөнхий газрын хаягийг бичиж, Enter товч дар. Нийгмийн даатгалын ерөнхий газрын вэб сайт таны хөтөч дээр гарна.



 Сайтны баруун хэсэгт байрлах "ДААТГУУЛАГЧИЙН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТ, НЭРИЙН ДАНСНЫ ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ" холбоос дээр дарж, бүртгэлийн хэсэгтэй холбогдоно.

🕒 Нийгмийн даатгал 🔸 🗙 🗋 www.ndaatgal.mn/regnd/ 🗴 🦲	- • ×
← → C 🗋 www.ndaatgal.mn/regnd/	Q ☆ =
НИЙГМИЙН ДААТГАА даатгуулагчийн мэдээлэл	
Та эхлээд <u>ЭНД ДАРЖ</u> бүртгүүлнэ үү. <mark>Бүртгүүлэх Заавар татах</mark> Та мэдээллээ бүртгүүлж, баталгаажуулснаар 2006 оноос хойш шинтгэл төлөлт болон нэрийн дансны м инэйлээр авах боломжтой.	эдээллээ
Регистер :	
Нууц үг :	
Нэвтрэх	
Бүртгүүлсний дараа танд инзйл ирзэгүй болон нууц үгээ инэйл рүүгээ дахин авах бол . <u>ЭНД дарн</u>	1 <u>17</u> .

 "Бүртгүүлэх заавар татах" холбоос дээр дарж, зааврын файлыг татаж, танилцана уу. ✓ Зааврын дагуу мэдээллээ бүртгүүлж, баталгаажилт хийснээр танд нийгмийн даатгалын мэдээллээ авах боломж бүрдэнэ. Хэрэв та и-мэйл хаягаараа хүлээж авах ангиллыг сонгосон бол дараах байдлаар шимтгэл төлөлт, нэрийн дансны мэдээллээ хүлээн авна.

	/mail.google.com/mail/u/0/#search/%D0	%BD%D0%B8%D0%B9%D0%B3%D0%BC%D0%B8%D0%B9	%D0%BD+%D0)%B4%D0%B0%D0%≪ ೯
Google	нийгмийн даатгалын санд төлсөн	۱	В	attsetseg 🏢 ዐ 🧲
Smail +	G More *		1-6	of 6 < > 🔯 -
COMPOSE	🔲 ★ 🍺 User User	Inbox Fwd: Нийгмийн даатгалын санд төлсөн 2012 оны шимт	12/17/13	
COMPOSE	🔲 ★ 🍉 User User	Inbox Fwd: Нийгмийн даатгалын санд төлсөн 2011 оны шимт	12/17/13	
tarred	🔲 ★ 🍺 Нийгмийн даатгал	Inbox Нийгмийн даатгалын санд төлсөн 2010 оны шимтгэл те	12/17/13	
nportant	🔲 ★ 🍺 Нийгмийн даатгал	Inbox Нийгмийн даатгалын санд төлсөн 2009 оны шимтгэл те	12/17/13	
hats	🗌 ★ 🍉 Нийгмийн даатгал	Inbox Нийгмийн даатгалын санд төлсөн 2008 оны шимтгэл те	12/17/13	
ent man	🗆 🔸 💌 Нийгмийн дээтгэл	Inbox Нийгмийн даатгалын санд төлсөн 2007 оны шимтгэл те	12/17/13	Sign in

Мөн та эрүүл мэндийн даатгалын урамшуулын үзлэгт хамрагдах эсэхээ шалгаж болно. Үүний тулд дараах алхмуудыг хийнэ.

Сайтны баруун хэсэгт байрлах "ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН УРАМШУУЛЛЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ ЭСЭХИЙГ ШАЛГАХ" холбоос дээр дарснаар урамшууллын оношилгоо, шинжигээний багц болон үйлчилгээ үзүүлэх эмнэлгүүдийн мэдээлэлтэй танилцаж болно.

☐ Нийгмийн даатгал	
← → C 🗋 www.ndaatgal.mn/emdprom3/	২ ☆ =
ЭМНЭЛЭГ НЭВТ	ЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧ ТА УРАМШУУЛЛЫН ҮЗЛЭГТЭЭ ХАМРАГДААРАЙ	
Даатгуулагч Та дараах нөхцөлийг хангасан тохиолдолд урамшууллын оношлогоо, шинжилгээний багцаас сонгон нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эмнэлэгүүдэд эрүүл мэндийн бүрэн үзлэгт нэг удаа хамрагдах эрхтэй. Үүнд :	
✓ Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ жил бүр тогтмол хугацаанд нь төлсөн бол✓ Дараалсан 3 жилийн хугацаанд буюу 2012/01/01 -ээс 2015/01/01 -ний хооронд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын төлбөр гаргуулаагүй бол.	
Даатгуулагч Та урамшууллын оношлогоо, шинжилгээний багц болон эмнэлэгээ өөрөө сонгох боломжтой.	
Багц-1 харах / Багц-2 харах / Багц-3 харах / Эмнэлэгүүдийн нэрс харах Еренхий/ Хавдар/ Харшил/	
Даатгуулагч Та урамшууллын үзлэгт хамрагдах эрх үүссэн эсэхээ регистерийн дугаараа оруулан шалгана уу.	
Регистерийн дугаараа оруулна уу:	
Та 2011/01/01 -зэс 2014/01/01 -ний хооронд эрүүл мэндийн даатгалаа хугацаанд нь тасралтгүй телеөгүй тул хамрагдах боломжгүй байна. Хэрвээ та энэ хугацаанд тасралтгүй төлсөн бөгөөд энэхүү системээр таны мэдээлэл гарч ирэхгүй бол харъяа нийгмийн даатгалын хэлтэстээ хандаж шалгуулна уу.	
2014 © Нийгмийн Даатталын Ерөнхий Газрын дэргэдэх Мэдээллийн Технологийн Төв	-

✓ Та "Регистрийн дугаараа оруулна уу:" хэсэгт мэдээллээ оруулж урамшууллын үзлэгт орох боломжтой эсэхээ шалгаарай.

Нийгмийн халамж, үйлчилгээ

Монголын нийгмийн халамж, үйлчилгээний газар нь нийгмийн халамж, асрамжийн үйл ажиллагааг улсын хэмжээнд түргэн шуурхай, чанартай үр дүнтэй зохион байгуулах, хүн

ам, гэр бүлийн хөгжлийг хангах, тэдний нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэхийн тулд вэб сайт (http://www.halamj.gov.mn/)-aapaa дамжуулан ард иргэдийн санал, зөвлөмжийг авахаас хүлээн гадна нийгмийн халамж, үйлчилгээний газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэж байна.

Та энэ сайтны баруун хэсэгт байрлах "САЛБАР ХЭЛТЭСҮҮД" хэсгээс орон нутаг дахь нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг авах боломжтой.





<u>Татварын үйлчилгээ</u>

Монголын татварын ерөнхий газар нь веб сайт (<u>http://www.mta.mn/</u>) -аараа дамжуулан иргэдэд байгууллагынхаа талаарх мэдээ, мэдээллийг хүргэхээс гадна иргэд, ААН, байгууллагуудад зориулсан олон үйлчилгээг хүргэж байна. Үүний нэг жишээ нь өмнө нь татварын алба, хэлтсүүдээс өөрийн биеэр очиж авдаг байсан татварын баримт, бичгүүдийг одоо татварын газрын вэб сайтнаас татаж аван, нэг цэгийн үйлчилгээний төвүүдээр үйлчлүүлэх боломж бүрдсэн байна.



Энэ мэтээр төрийн байгууллагууд МХХТ-ийг үйл ажиллагаандаа ашиглан иргэдэд нээлттэй үйлчилгээг үзүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлснээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, үйлчилгээг илүү үр дүнтэйгээр иргэдэд хүргэхэд ихээхэн ач холбогдолтой.

Интернэт банк

Интернэтэд холбогдсон дурын компьютерээс тухайн банкны вэб хуудсыг ашиглан, банкны үйлчилгээг цаг хугацаа, орон зайг үл харгалзан хүссэн үедээ авах боломжтой үйлчилгээ юм. Та мөн интернэт банкны аппликейшныг өөрийн Android, iOS, Blackberry үйлдлийн систем бүхий гар утсандаа суулгаж, уг үйлчилгээнүүдийг авах боломжтой. Интернэт банк ашигласнаар өөрийн бүх дансыг хянах, удирдах, бүх төрлийн мөнгөн шилжүүлэг хийх, хадгаламжийн данс, карт нээлгэх гэх мэт банкны үйлчилгээний захиалга өгөх, валютын арилжааны хэлцэл хийх болон бусад олон төрлийн үйлчилгээг авах боломжтой. Та интернэт банк ашиглах зааврыг тухайн банкны веб сайтаас харна уу.

- ✓ <u>https://www.statebank.mn</u> Төрийн банк
- ✓ <u>https://www.khanbank.com/</u> Хаан банк
- ✓ <u>https://www.ebank.mn/</u> Худалдаа Хөгжлийн банк
- ✓ <u>https://s.egolomt.mn/</u> Голомт банк
- ✓ <u>https://www.e-xacbank.com</u> Хас банк
- ✓ <u>https://ebank.ubcbank.mn/ebank/</u> Улаанбаатар Хотын банк

Аль ч банкны интернэт үйлчилгээг авахын тулд та тухайн банкны өөрт ойр салбарт хандах хэрэгтэй.

Мэдлэг боловсролоо дээшлүүлэх боломж

Боловсрол олох эрх нь хүний үндсэн эрхийн нэг бөгөөд боловсрол нь ядуурал болон нийгэм дэх бусад тэгш бус байдлыг бууруулахад чухал үүрэгтэйгээс гадна өөр олон шалтгааны улмаас боловсролыг чухалчлан үздэг. Боловсролын салбарт МХХТ-ийг ашиглах нь чухал ач холбогдолтой. Ядуурал, хөгжлийн бэрхшээл, газар зүйн байрлал, хүйс, мөргөлдөөн, ажил эрхлэлт, соёлын хязгаарлалт зэргээс хамааран сургуульд суралцах боломжгүй хэн бүхэнд МХХТ нь боловсрол олгох боломжтой.

Интернэтэд МХХТ-ийг ашигласан онлайн буюу зайн сургалт, сургалтын материалууд элбэг байдаг. Тэдгээрийг бид хайлтын системүүдийг ашиглан "онлайн сургалт", "online learning" гэсэн түлхүүр үгүүдээр хайж, өөрийн сонирхсон сургалтыг хүлээн авах боломжтой.

Онлайн сургалтууд нь дотоодын болон гадаадын их, дээд сургуулиудтай интернэт ашиглан холбогдсоноор зайнаас өөрийн сонирхсон сургалтаа хүлээн авахаас гадна мэргэжил дээшлүүлэх, боловсролын зэрэг ахиулах бололцоог бидэнд олгодог.

Дараах үнэгүй онлайн сургалтын сайтуудыг санал болгож байна. Үүнд:

http://emust.edu.mn/ - ШУТИС-ийн е-Нээлттэй институт

http://www.one.mn/ - Нээлттэй мэдлэг боловсролын сан

<u>https://www.khanacademy.org/</u> - АНУ-ын Хан академийн нээлттэй сургалтын сайт. Тус сайтыг ЕБС-ийн багш, сурагчид, эцэг эхчүүд ашиглах боломжтой. Тус сайтны хичээлүүд нь суралцагчдад мэдлэгийн салбарын ойлголтыг энгийнээр таниулж, түүний учир шалтгааныг ухаарч ойлгох, бодож тунгаах, бүтээлчээр суралцах арга барил эзэмших, ойлгосноо амьдралд хэрэглэх бодит ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн байдгаараа онцлог.

<u>http://kids.nationalgeographic.com/</u>, <u>http://www.funbrain.com/</u> - Бага насны хүүхдэд зориулсан сургалтын сайтууд. Бичлэг, эвлүүлдэг тоглоом, зураг зурах, тоо бодох, унших гэх мэт хүүхдийн сонирхлыг татахуйц хичээлийн сантай. Эдгээр сайтууд нь тоглоом хэлбэрээр хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэхэд чиглэсэн.

http://patrickjmt.com/ - Матетатикийн хичээлийн сайт

http://film-english.com/, http://www.filmeducation.org/ - Кино үзэнгээ Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх сайт

http://www.engvid.com/ - Англи хэлний видео хичээл, дасгал, тестийн сан

<u>http://ed.ted.com/</u> - Бүх талын мэдлэгээ дээшлүүлэхэд зориулагдсан сайт. Хичээлүүд нь маш сонирхолтойгоор хийгддэгээрээ онцлог.

<u>www.coursera.org</u>, <u>www.openculture.com</u> – Олон улсад нэр хүндтэй их, дээд сургуулиудтай хамтран ажилладаг онлайн сургалтын сайт, сертификат авах боломжтой.

<u>www.stanford.edu</u>, <u>www.extention.harvard.edu</u>, <u>www.oyc.yale.edu</u> - АНУ-ийн дэлхийд нэр хүндтэй сургуулиудын зохион байгуулдаг онлайн сургалтын сайт. Ганцаарчилсан болон улирлын сургалтын сонголттой.

<u>http://www.london.ac.uk/podcast.html</u> - Лондонгийн их сургуулиас зохион байгуулдаг онлайн сургалтын сайт. Нарийвчилсан судалгаа хийх боломж бүхий өгөгдлийн сантай.

Өдөр тутмын мэдээ, мэдээлэл авах

Мэдээлэл үнэ цэнэтэй болсон өнөө үед аливаа мэдээллийг цаг алдалгүй, шуурхай хүлээж авах нь юу юунаас чухал болжээ. Өнөөдөр улс орон, хувь хүний хүч чадал, эрх мэдэл нь тэдний олж авсан мэдээлэл, мэдлэгээр хэмжигдэх болсон байна. Интернэт ашиглан дэлхий дахинд болж буй үйл явдлуудын талаар хугацаа алдалгүйгээр хүлээн авах боломжтой. Жишээ нь мэдээний сайтуудаас дэлхий дахинд болж буй үйл явдлын талаар,

цаг агаарын мэдээ, зурхай, үнэ ханшийн мэдээ зэргийг авч болно. Мөн сүүлийн жилүүдэд олон нийтийн радио, телевизүүд нь нэвтрүүлгээ интернэтээр шууд цацдаг болоод байна.

- ✓ <u>http://news.gogo.mn/</u> Монголын үндэсний мэдээний сайт
- ✓ http://news.mn/ Монголын үндэсний мэдээний сайт
- ✓ http://mnb.mn/ Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн сайт
- ✓ <u>http://bloombergtv.mn/</u> Монгол дахь Блүүмберг телевизийн сайт
- ✓ <u>https://www.onair.mn/</u> Монголын телевизүүдийн шууд эфирийн сайт

<u>http://news.gogo.mn/</u> - Монголын үндэсний мэдээний сайт руу хандацгаая. Эндээс та дэлхий дахинд юу болж байгаа талаар мэдээ, мэдээлэл авахын сацуу зурхай, цаг агаарын мэдээ, валютын ханшийн мэдээлэл, ТВ хөтөлбөр зэргийг харах боломжтой.



<u>https://www.onair.mn/</u> - Монголын телевизүүдийн шууд эфирийн сайт руу хандацгаая. Эндээс та Монголын аль ч телевизийн нэвтрүүлгийг шууд хүлээн авч үзэх боломжтой.

🖉 🗠 OnAir.mn - Nati	onal Cont 🗙 🔪		contraction in second		-				
← ⇒ C	tv.onair.mn								☆ =
		21	an			🔒 Hər	атрэх 👈 Бүртгүүлэ	ex 🌔 Android	🔹 Apple 🛛 🔿 🄶
on air	Са ТВ	б 🗊 Кино Видео	🖪 🧧 Нэвтрүүлэг Хүүх,) дийн Бусад ▼			🚼 Select	t Language 🔻	
🖵 Телевиз	зүүдийн шу	уд эфир							🗄 ТВ хөтөлбөр
MNB	MN 2	- c1 -		240	ntv		eagle News	SBN	ти
@	ĝ	RAA	AK KMO 1		FASHION	27	MOVE DOX		ୢୄୗ୲୦ୄ୲୴
SEVEN	SPORT	STAR HS	eco	f	C Bush	ROYAL	MNC		23
	HiV	SHOR	TB1 CYNA	MASS	() ^{tv}	10	C Essences	модор	
🏸 Яг одоо									
	SPORT box					MIN.C.			im.
SportBox HD 📕 "Универсиа іл - Германа	ЕС ад 2015: 17 3 ам	CO Channel 📕 :00 "Дэлхий дээрх ıьдрал" цуврал	Olloo TV 🗖 17:10 TB xi	ічээл: №34	МNC HD ■ 17:00 "17 Цаг" хөтөлбөр	Эрү мэдээллийн 17:	үл Мэнд 📕 30 Дасгалын цаг	Сүлд ТВ 17:00 Өн Занабаз	ңар гэгээн арын Бат-С
10					14:09:18:00	4	104 PC		

Зарим чухал сайтууд

http://tsevel.toli.query.mn/ - Монгол хэлний товч тайлбар толь буюу "Цэвэлийн ногоон толь".

"Монгол хэл бол манай ард түмний өндөр соёлыг тусгасан баялаг хэл юм."

Я.Цэвэл

Та энэ сайтнаас сонирхсон үгийнхээ зөв бичиглэл, утгын тайлбар, утгыг нэмэн тодруулсан утга зохиолын жишээ, монгол бичлэгийг бичгийн xapax Тайлбар боломжтой. толины үгсийн санг Сонирхолтой,



Шинэ, Эрэлттэй, Төрөл гэсэн ангиллуудад хуваасан нь үг хайхад дөхөм болсон.

Мөн, Та тайлбар толины үгсийн санд өөрийн нутгийн аялгууны өвөрмөц нандин үгс, холбогдох мэргэжлийн нэр томъёо, нийгмийн хөгжлийг даган гарч буй шинэ үг зэргийн утгын тайлбарыг нэмж оруулах боломжтой. Ингэснээр та эх болсон Монгол хэлнийхээ электрон тайлбар толь бичгийг бүтээх их үйлсэд хүчээ өгөх болно.

Энэхүү тайлбар толь нь Монгол түмний соёл, сэтгэлгээний дархлаа болсон эх хэлний нийгмийн үүргийг дээшлүүлэхэд онцгой ач холбогдолтой.

http://www.bolor-toli.com/ - Олон хэлний толь бичгийн сайт.



Болор толь бичиг нь Англи-Монгол, Герман-Монгол, Солонгос-Монгол, Япон-Монгол хэлний толь бичгүүдийг өөртөө агуулдаг бөгөөд одоогоор Англи 453059, Герман 46653, Солонгос 27203, Япон 20962 үгсийн сантай. Мөн та кирилл бичгээс гадна монгол бичгээр үг хайж, ашиглах боломжтой.

ХАЙЛТЫН СИСТЕМ АШИГЛАН МЭДЭЭЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ

Интернэт нь асар их мэдээллийг өөртөө агуулдаг. Эдгээр мэдээлэл нь дэлхийн олон орнуудад байрлах вэб серверүүд дээр хадгалагдаж байдаг бөгөөд ямар мэдээлэл аль сервер дээр хадгалагдаж байгааг тодорхойлох нь маш төвөгтэй нь ойлгомжтой. Энэ их мэдээллийн уурхайгаас өөрт хэрэгтэй мэдээллээ хайж олохын тулд бид хайлтын системийг ашигладаг.

Хайлтын систем гэдэг нь интернэт сүлжээнд хэрэглэгчийн текст хэлбэрээр бичиж асуусан лавлагаанд холбогдох мэдээллийн эх сурвалжийн линкүүдийг ач холбогдлын дарааллаар нь жагсаан харуулах зориулалттай програм хангамжийн систем юм. 2015 оны байдлаар хамгийн өргөн ашиглагдаж байгаа хайлтын системүүдийг дараах хүснэгтээр харууллаа.

N₽	Хайлтын систем	URL хаяг	Сарын дундаж хайлтын тоо
1	Google	www.google.com	1,100,000,000
2	Bing	www.bing.com	350,000,000
3	Yahoo! Search	https://search.yahoo.com	300,000,000
4	ASK Search	www.ask.com	245,000,000
5	Aol Search	http://search.aol.com	125,000,000

Та дээр дурдсан хайлтын системүүдийн алийг ч ашиглаж болно. Үүний тулд хайлтын системд өөрийн хайж, олохыг хүссэн зүйлтэй холбоотой үг эсвэл өгүүлбэр бичиж асуух ба хайлтын систем өөрийн өгөгдлийн сангаас хайлт хийж, хэсэг хугацааны дараа таны хайлтын утгад тохирох вэб сайтуудын жагсаалтыг дэлгэцэнд харуулна.

Интернэтээс хайлт хийх

Google хайлтын системийг ашиглан хайлт хийж үзэцгээе. Вэб хөтчийн хаягийн хэсэгт <u>http://www.google.com</u> хаягийг бичиж хайлтын системээ ажиллуулаад хайлтын хэсэг дээр хайх үг эсвэл өгүүлбэрээ бичээд *Enter* товч дарна.

Дараах жишээнд **Google** хайлтын системд "**Мэдээлэл, харилцаа холбооны технологи**" гэсэн хайлтын утгыг оруулж өгсөн бөгөөд хайлтын үр дүнд дэлгэцэнд холбогдох эх сурвалжуудын линкүүдийг ач холбогдлын дарааллаар нь жагсаан харуулсан байна.

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ГАРЫН АВЛАГА



Монголын үндэсний хайлтын систем

Интернэт хэрэглэгчийн тоо ихсэх тусам өөрийн хэлний онцлогт тохирсон дотоод мэдээллийнхээ эргэлтийг сайжруулах үүднээс үндэсний хайлтын системийг хөгжүүлэх нь ач холбогдолтой.

Манай улсад хоёр үндэсний хайлтын систем хөгжүүлэгдэн ажиллаж байна. Үүнд:

- www.nuudel.mn Нүүдэл үндэсний хайлтын систем
- www.moogol.mn Моогол үндэсний хайлтын систем

Түлхүүр үг, өгүүлбэрийн хэрэглээ

Ихэнх хүмүүс хайлтын системийг ашиглахдаа өөрт шаардлагатай мэдээллийг ямар ч тохиолдолд хүссэнийх нь дагуу гаргаж ирнэ гэж боддог. Гэтэл үнэн хэрэгтээ хайлтын системүүд нь зөвхөн тухайн системд бүртгэгдсэн сайтуудын жагсаалтаас л хайж, үр дүнг харуулдаг. Иймээс ялгаатай хайлтын системийг ашиглах үед үр дүн мөн ялгаатай байж болно. Түүнчлэн хайлтын системүүдийн хайлтын үр дүнг жагсаах шалгуур нь өөр өөр байдгаас шалтгаалан таны компьютерийн дэлгэцэнд харуулах үр дүнгийн жагсаалт ижил биш байх магадлалтай.

Интернэт нь асар их мэдээллийг агуулдаг тул тухайн сэдвээр хайлт хийхдээ хэтэрхий нийтлэг, дэлгэрэнгүй үг хэрэглэхээс зайлсхийж, хайж буй мэдээллээ олж гаргаж ирэхийн тулд хайлтын түлхүүрийг илүү тодорхой болгох хэрэгтэй. Жишээ нь та дараах хайлтын аргуудыг туршиж үзээрэй. Үүнд:

Тодорхой утгаар хайх

Хэрэв та хайлт хийхдээ **хүүхдийн дуу** гэсэн 2 үг хэрэглэвэл, хайлтын систем ихэвчлэн **хүүхдийн**, **дуу**, **хүүхдийн дуу** гэсэн утгуудтай холбоотой бүхий л хуудсуудыг хайж олно. Харин үүний оронд **хүүхдийн+дуу** гэж бичээд хайвал **хүүхдийн**, **дуу** гэсэн үгнүүдийг агуулсан сайтуудыг гаргаж ирнэ.

Оновчтой утгаар хайх

Яг тухайн утгаар хайх үедээ (") хашилтыг ашиглана. Жишээ нь *"хүүхдийн дуу"* гэж хайвал яг *хүүхдийн дуу* гэсэн холбоо үгийг агуулсан сайтуудыг гаргаж ирнэ.

Угний тодорхойлолтыг хайх

Ямар нэгэн үгний тодорхойлолтыг мэдэхийг хүсвэл "define:" гэж бичээд ард нь тухайн үгээ бичиж хайхад толь бичгийн тайлбар гарч ирнэ.

Тодорхой үгийг хасч хайлт хийх

Жишээ нь: "кексний жор -өндөг" гэж хайвал өндөг гэсэн үг ороогүй кексний жорууд гарч ирнэ.

Ойролцоо утгаар хайх

Хэрэв хайлт хийх гэж байгаа зүйлийг олон үгээр илэрхийлж болдог бол (~) тэмдгийг ашиглана. Жишээ нь: "~амар амгалан" гэж хайхад амар амгалан, дотоод амгалан гэх утгуудыг агуулсан сайтууд гарч ирнэ.

✓ Тодорхой үнийн хэлбэлзэлд хайх

Ямар нэгэн зүйлийг худалдаж авахад чанараас гадна үнэ их чухал үзүүлэлт болдог. Тэгвэл хайлтын системээс сонирхсон зүйлээ тодорхой үнийн хязгаарт хайх бололмжтой. Жишээ нь: гутал ₮100000..₮250000 гэж хайж болно.

Тухайн сайтнаас мэдээлэл хайх

Та нэг вэб сайтнаас мэдээ хайх гэж байгаа бол "site:" түлхүүр үгний ард вэб сайтны нэр болон мэдээнийхээ түлхүүр үгийг бичээд хайна.

Файлын төрлөөр хайх

Файлын төрлөөр хайхыг хүсвэл хайх зүйлийнхээ түлхүүр үгний ард "filetype:*файлын төрөл*" гэж бичнэ. Жишээ нь: "интернэт filetype:PPT" гэж хайвал интернэтийн талаарх илтгэлийн файлууд гарч ирнэ.

Бодлогын хариуг олох

Та тэгшитгэл болон илрэхийлэл бичээд хайхад Google танд хариуг нь гаргаж өгнө.

Сэрүүлэг тавих

Жишээ нь "set timer for 10 minutes" гэж бичээд хайхад Google танд 10 минутын дараа дуугараха сэрүүлэг эхлүүлж өгнө

✓ Валютын ханш тооцох

Жишээ нь долларын ханш хэд байгааг мэдэхийг хүсвэл "USD to MNT" гэж бичээд хайна.

Дээрх маягаар Google хайлтын системээс оновчтой, үр дүнтэй хайлт хийх олон түлхүүрүүд байдаг.

ЭЛЕКТРОН ШУУДАН

Интернэт ашиглан шуудан илгээх, хүлээн авах үйлчилгээг электрон шуудан (e-mail) гэж нэрлэдэг. Монголчууд имэйл гэж товчлон бичиж, ярьж хэрэглэдэг.



2015 оны байдлаар дэлхийн даяар 1 секундэд 2,4 сая электрон шуудан дамжигдаж байна.

Электрон шуудангийн үйлчилгээг ашиглахын тулд интернэт холболт бүхий компьютер, гар утас болон өөрийн электрон шуудангийн хаягтай байх шаардлагатай.

Электрон шуудангийн үйлчилгээг ашигласнаар захидал солилцохоос гадна бие биетэйгээ дүрстэй болон дуут шуудангийн үйлчилгээ авч болно.

Жишээ нь сүүлийн жилүүдэд хүчээ авсаар байгаа "Google"-ийн электрон шуудан болох "Gmail"-ийг ашигласнаар Google компаниас үзүүлэх 150 гаруй үйлчилгээг авах боломж бүрдэнэ.

GMAIL ЭЛЕКТРОН ШУУДАН БОЛОН ТҮҮНИЙ БОЛОМЖУУД

Gmail электрон шуудан



Gmail нь өөрийн хэрэглэгчиддээ хязгааргүй тооны захидал хадгалах боломж болон нууцлалын механизмуудаар хангадаг.

Gmail электрон шуудангийн үйлчилгээг авахын тулд Gmail электрон шуудангийн хаягтай байх хэрэгтэй. Хэрэв танд байхгүй бол шинээр нээх хэрэгтэй. Шинээр хаяг үүсгэхийн тулд дараах алхмыг хийнэ. Үүнд:

Gmail

<u>https://accounts.google.com/signup</u> сайт руу хандан, шаардлагатай мэдээллүүдийг бөглөж илгээснээр та өөрийн шинэ хаягтай болох бөгөөд ингэснээр захидал илгээх, хүлээн авах, чатлах, дуут болон дүрстэй дуудлага хийх зэрэг олон боломжууд бий болно.

Gmail нь маш олон давуу талуудтай бөгөөд заримаас нь дурдвал:

- ✓ Gmail-ийн хайлт нь маш хурдан, ухаалаг. Хайлт хийх утгын аль нэг хэсгийг бичихэд л тухайн хайлтын утга орсон хайж болох утгуудыг санал болгодог.
- ✓ Gmail-ийн захиа хадгалах хэмжээ нь 30GB-аас 16TB хүртэл ихэсгэх боломжтой. Тиймээс танд захиануудаа нөөцөлж авах шаардлага гарахгүй.
- ✓ Захидлуудыг "харилцан яриа" болгон зохион байгуулдаг. Хэн нэгэн тань руу захидал илгээж, та хариу захиа бичсэн бол эх захидал нь хамгийн дээр байрлаж, түүнээс доош энэ захидалтай холбоотой харилцсан захидлууд харгалзан багцлагдсан байдлаар зохион байгуулагддаг. Энэ нь олон олон захидлуудыг эмх цэгцэнд оруулж, ажиллахад таатай нөхцлийг бүрдүүлдэг.

✓ "Яана аа, буруу мэйл илгээчихсэн үү?" Тэгвэл Gmail-ийн Undo Send команд танд тусална. Өөрөөр хэлбэл Undo Send тохиргоог идэвхжүүлснээр та 30 хүртэлх секундын хугацаанд илгээсэн мэйлээ болиулах боломжтой.

Google+



Google+ нь Gmail электрон шуудангийн хаягаараа шууд холбогдох боломжтой олон нийтийн сүлжээ юм. 2015 оны байдлаар 1,3 тэрбум идэвхтэй хэрэглэгчтэй байна.

Google+

Энэ сүлжээ нь бусад олон нийтийн сүлжээний адил өөрийн тухай товч мэдээлэл үүсгэх, зураг болон видео байршуулах, мессеж илгээх, нийтлэл бичих, найз нөхөд, гэр бүл, хамт олонтойгоо харилцах боломжийг

олгодгоос гадна ажил хэргийн талаар хэлэлцэж, сонирхлын хүрээлэл үүсгэхэд их зохимжтой.

Google Talk



Энэхүү програм нь Gmail электрон шуудангийн хаягаа ашиглан бодит агшинд дэлхийн хаанаас ч интернэтээр бие биетэйгээ харилцах боломжийг олгодог. Google Talk-д харилцагчийн хаягийг бүртгэснээр мессежээр харилцах, зураг болон видео хамтран ашиглах, файл

дамжуулах, дуут болон дүрстэй дуудлага хийх зэрэг олон үйлчилгээ авах боломж бүрдэнэ. Мөн компьютер болон ухаалаг гар утас хооронд холболт тогтоох боломжтой.





Google Docs



Google Docs нь бичиг баримт боловсруулах онлайн хэрэгсэл юм. Та Google Docs-ийг ашиглан текстэн болон хүснэгтэн мэдээлэл, илтгэлийн файл бэлтгэхээс гадна ажлаа төлөвлөж, судалгаа авсан ч болно. Гайхалтай нь энэ бүх үйлдлийг та зөвхөн нэг компьютер дээр биш интернэтэд холбогдсоноор хаанаас ч хийх боломжтой. Өөрөөр хэлбэл таны компьютер дээр баримт бичиг боловсруулах

програм хангамж суугаагүй байсан ч та ажлаа хийх боломжтой гэсэн үг. Мөн та ажлын баг үүсгэн нэг файлыг олон хүнд нээлттэй болгож, багийн гишүүдэд засварлах эрх өгсөн ч болно. Ингэснээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран багаараа ажиллах сайхан боломж бүрдүүлж байгаа нь үнэхээр гайхалтай.

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ГАРЫН АВЛАГА



Google Drive



Google Drive нь 30GB-100GB багтаамжтай таны онлайн хадгалах төхөөрөмж юм. Өөрөөр хэлбэл та Google Drive-ийг ашигласнаар интернэт орчинд хаанаас ч хэрэгцээт файл руугаа хандах боломжийг бүрдүүлнэ. Энэ нь баг, хамт олноороо хамтран хийж байгаа ажил, төслийн үед ихээхэн ач холбогдолтой. Google Drive-даа хамтран эзэмших файлуудаа хадгалснаар багийн аль ч гишүүн интернэт орчинд хаанаас ч хэрэгцээт файл руугаа хандан ажлаа хийж болно. Мөн Google Drive нь Google Docs-

Drive

той шууд холбогдон ажилладаг тул та онлайн орчинд шууд ажиллах боломжтой.

Na Inbox (13) - ebajina@gma ×	A My Drive - Google Drive ×			
← → C 🔒 https://drive	e.google.com/drive/my-drive			☆ =
Google	Search Drive	Ŧ	Q Battsetseg	III o 🔵
🝐 Drive	My Drive 👻	G) 🏰 🧿	• • •	ÂZ D C
NEW	Name 🛧	Owner	Last modified	File size
▶ 🔼 My Drive	Big Data	me	Jan 14, 2015	-
Shared with me	Cisco	me	Jan 7, 2015	-
Google Photos	Computer Networks	me	Jun 23, 2015	-
Starred	Data Mining	me	7:33 pm	-
Trash	Database	me	7:35 pm	-
Get Drive for PC	eLesson	me	Feb 12, 2015	-
	eOffice	me	Jan 14, 2015	-
3 GB used (20%) Buy more storage	СТ	me	7:34 pm	-

Google Translate



Google Translate нь олон хэлний онлайн хөрвүүлэгч систем бөгөөд Монгол, Англи, Орос, Герман, Япон, Хятад, Солонгос, Франц гээд 70-аад түгээмэл хэлүүдийн хооронд үгээр болон өгүүлбэрээр, зурагнаас, хүний ярианаас болон синхрон орчуулга хийх боломжтой.



Google Translate нь вэб болон мобайл (Android, iOS) интерфейсийн аль алиныг дэмждэг. Мөн Google Chrome вэб хөтөч дээр Google Translate-ийг ашиглаад ямар ч хэл дээрх сайтын агуулгыг хүссэн хэл рүүгээ орчуулан унших боломжтой болсон байна. Сурч боловсроход үнэхээр сайхан боломж биш гэж үү.

Google Scholar



Google Scholar нь интернетэд байрлуулсан эрдэм шинжилгээний сэтгүүлүүд дээр хэвлэгдсэн нийтлэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, диссертацийн ажил, ном, судалгаа шинжилгээний дүгнэлтүүд, шинжлэх ухааны байгууллагууд, мэргэжлийн хүрээлэнгүүд,

судалгааны бүлгэмүүдийн тайлангууд болон тэдгээрийн хураангуй зэрэг өргөн хүрээг хамарсан эрдэм шинжилгээний бүтээлүүдийн бүрэн эх болон ишлэлүүд дундаас хайлт хийх боломжийг олгодог. Өөрөөр хэлбэл интернет дэх эрдэм шинжилгээний бүтээлүүдийг та бид ашиглах боломжтой боллоо гэсэн үг юм.

Google Books



Google Books нь онлайн номын сан бөгөөд маш олон ном сэтгүүлүүдийг албан ёсны эрхтэйгээр тоон хэлбэрт шилжүүлэн олон нийтэд хүргэдэг үйлчилгээ юм.

нийгмийн сүлжээ

FACEBOOK ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ



Facebook бол түүнд бүртгэлтэй хэрэглэгчдэд өөрийн тухай товч мэдээлэл үүсгэх, зураг болон видео байршуулах, мессеж илгээх, мөн найз нөхөд, гэр бүл, хамт олонтойгоо холбоотой байх боломжийг олгодог үнэгүй, өргөн дэлгэрсэн олон нийтийн сүлжээний вэб сайт юм.

Олон нийтийн энэ сүлжээ нь 2015 оны байдлаар 1,4 тэрбум идэвхтэй хэрэглэгчтэй байна.

Уг сайт нь 37 өөр хэл дээр ашиглах боломжтой ба доор дурдсан онцлогуудыг агуулдаг. Үүнд:

- ✓ Зах зээлийн талбар ангилагдсан зар сурталчилгаанд өөрийн зарыг оруулах, зар унших болон хариу хэлэх гэх мэт үйлдэл хийхийг зөвшөөрдөг.
- ✓ Бүлгүүд нийтлэг сонирхолтой гишүүдэд бие биенийгээ хайж олох болон харилцах боломжийг олгодог.
- ✓ Үйл ажиллагаа зохион байгуулагдах гэж буй үйл ажиллагааг олон нийтэд зарлах, зочдыг урих болон оролцох төлөвлөгөөтэй хэн нэгнийг мэдэх боломжийг гишүүдэд олгодог.
- ✓ Хуудаснууд тодорхой сэдвийн хүрээнд олон нийтийн хуудсыг үүсгэх болон түүнийг дэмжих боломжийг гишүүдэд олгодог.
- ✓ Оршихуй технологи сүлжээнд байгаа (онлайн) харилцагчдыг харах болон чатлах боломжийг гишүүдэд олгодог.

Facebook олон нийтийн сүлжээнд холбогдохын тулд заавал Facebook хаягтай байна. Хэрэв танд байхгүй бол шинээр нээх хэрэгтэй. Facebook хаяг шинээр үүсгэхийн тулд дараах алхмыг хийнэ. Үүнд:

 <u>https://www.facebook.com/</u> сайт руу хандан, шаардлагатай мэдээллүүдийг бөглөж илгээснээр та өөрийн шинэ хаягтай болох бөгөөд ингэснээр Facebook-ийн олон үйлчилгээнүүдийг авах боломж бүрдэнэ.



TWITTER ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ



Twitter нь өөрийн твиттер бүлгийнхэндээ твиит гэж нэрлэгдэх богино хэмжээний мессежийг илгээх, хүлээн авах боломжийг олгодог олон нийтийн харилцааны сайт юм.

2015 оны 8 сарын байдлаар 322 сая гаруй идэвхтэй хэрэглэгчтэй бөгөөд 1 секундэнд 9,800 гаруй мессеж илгээгддэг байна.

Таны твиттер бүлэгт дараах хүмүүс багтана. Үүнд:

- ✓ Таны дагасан хүмүүс Та бусад твиттер хэрэглэгчдээс сонгон тэднийг дагаснаар тэдний нийтэлсэн мессежийг харах боломжтой.
- ✓ Таныг дагасан хүмүүс Твиттерийн бусад хэрэглэгчид таныг дагаснаар тэд таны нийтэлсэн мессежийг харах боломжтой болно.

Твиттер сүлжээ хэрэглэгчид нь 140 тэмдэгтэнд багтаан мессеж илгээдэг нь мэдээллийг түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэх нэг хэлбэр юм.

Твиттер сүлжээ нь олон салбарт тодорхой хэмжээгээр үр өгөөжөө өгсөөр байна. Жишээлбэл: Яаралтай онцгой мэдээлэл, түргэн тусламж, нийтийг хамарсан судалгаа, боловсрол, улс төр, нийгмийн харилцаа, бизнес, аялал жуулчлал гэх мэт.

Твиттер олон нийтийн сүлжээнд холбогдохын тулд электрон шуудангийн хаягаа ашиглан бүртгүүлэх хэрэгтэй. Бүртгүүлэхийн тулд дараах алхмыг хийнэ. Үүнд:

✓ <u>https://www.twitter.com/</u> сайт руу хандан, шаардлагатай мэдээллүүдийг бөглөж илгээснээр та твиттер сүлжээг ашиглах боломжтой болно.



МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Орчин үед хүн төрөлхтөний амьдралын хэв маягт МХХТ-ийн дэвшлүүд нэвтэрч, олон таатай боломжуудыг бий болгосоор байна. Ингэхийн хэрээр та бидний амьдрал МХХТ-оос ихээхэн хамааралтай болж, МХХТ-ийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, цар хүрээ нь өдрөөс өдөрт өргөжин тэлсээр байна. Энэ нь хувь хүн, байгууллага тэр ч бүү хэл улс үндэстэнг кибер халдлага, кибер терроризм, кибер гэмт хэрэгт өртөмхий болгож байна.

Иймд хувь хүн өөрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахаас эхлээд байгууллага, засгийн газар нь улс үндэстнийхээ мэдээллийн аюулгүй байдлын эсрэг заналхийллээс хамгаалах системүүдийг байгуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангахад ихээхэн ач холбогдолтой.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ

<u>Мэдээлэл</u>: Мэдээллийн аюулгүй байдлын салбарт мэдээллийг "үнэт зүйл-хөрөнгө" гэж тодорхойлдог. Энэ нь үнэ цэнэ бүхий зүйл учраас хамгаалагдах ёстой зүйл юм. Мэдээлэлд өгч буй ач холбогдол нь өнөөдөр хөдөө аж ахуйн нийгмээс аж үйлдвэрийн нийгэм рүү, эцэст нь мэдээлэлд чиглэсэн нийгэм рүү шилжих шилжилтийг харуулдаг.

Хөдөө аж ахуйн нийгэмд газар хамгийн чухал хөрөнгө байсан бөгөөд буудайн хамгийн том үйлдвэрлэлтэй орон өрсөлдөх чадвартай байдаг байв. Аж үйлдвэрийн нийгэмд газрын тосны нөөцтэй байх гэх мэт хөрөнгийн баталгаат байдал нь өрсөлдөх чадварын гол хүчин зүйл байсан. Мэдлэг, мэдээлэлд суурилсан нийгэмд, мэдээлэл нь хамгийн чухал хөрөнгө бөгөөд мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, ашиглах чадвар нь ямар ч улсын өрсөлдөх чадварыг илэрхийлэх давуу тал болоод байна.

Хүмүүсийн үзэл санаа бодит хөрөнгийн үнэ цэнээс мэдээллийн үнэ цэнийг үнэлэх үнэлэмж рүү шилжихийн хэрээр мэдээллийг хамгаалах ёстой гэсэн үзэл санаа улам гүнзгийрч байна. Мэдээлэл нь өөрөө түүнийг агуулж буй хэвлэл, мэдээллийн хэрэгслээс илүү үнэтэй зүйл юм.

<u>Мэдээлэлд учрах эрсдэл</u>: Мэдээллийн үнэ цэнэ өсөхийн хэрээр мэдээллийг олж авах, эзэмших, хянах хүсэл сонирхол хүмүүсийн дунд нэмэгддэг. Төрөл бүрийн зорилгоор мэдээллийг ашиглах бүлгүүд бий болж зарим нь мэдээллийг ямар ч хамаагүй аргаар олж авахыг хичээдэг болсон байна. Жишээ нь цахим халдлага, зохиогчийн эрх зөрчих, компьютерийн вирусээр мэдээллийн системийг гэмтээх гэх мэт.

Мэдээлэлд суурилсан орчинд дараах сөрөг нөлөөнүүд үүсч байна. Үүнд:

Нэр нууцлалтай байдлаас үүдэн гарах ёс зүйгүй үйлдлүүд ихэсч байна - Нийгмийн сүлжээ болон бусад олон интернэт харилцаанд бодит мэдээллээ хаалттай, нууцлагдмал байлгахыг зөвшөөрдөг. Ингэснээр хүмүүс мэдээллийг хууль бусаар олж авах, бусдын мэдээлэлд халдах зэргээр ёс зүйгүй, гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргах нөхцлийг бүрдүүлж байна.
Мэдээллийн эзэмшил ба хяналттай холбоотой зөрчилдөөн - Өнөөгийн мэдээлэлжүүлэлт, цахимжуулалтын үйл ажиллагаа өргөжиж байгаатай холбоотойгоор мэдээллийн хадгалалт, хяналттай холбоотой асуудлууд ихэссээр байна.

Дэвшилтэт технологиос үүдэн өсч буй мэдээллийн хандалт - Мэдлэг/мэдээлэлд суурилсан нийгэм бол сүлжээний нийгэм юм. Дэлхий бүхэлдээ нэг сүлжээ шиг холбогддог. Энэ нь сүлжээний аль нэг хэсгийн сул байдал нь бусад хэсэгтээ сөргөөр нөлөөлнө гэсэн үг юм.

<u>Мэдээллийн аюулгүй байдал</u>: Мэдээллийн аюулгүй байдал нь мэдээллийг хууль бусаар олж авахтай холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн улмаас үүсэх хохирлыг багасгахтай холбоотой үйл ажиллагаа юм.

Мэдээлэл болон мэдээллийн системд зөвшөөрөлгүй хандах, мэдээллийг ашиглах, зөвшөөрөлгүйгээр ил болгох, өөрчлөх, хуулбар үүсгэх, устгах, мэдээллийн системийн үйл ажиллагааг тасалдуулах, хянах, зогсоох зэрэг нь мэдээллийн аюулгүй байдалд халдаж буй гэмт хэргийн шинжтэй үйлдэл болно.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХАЛДАХ ХАЛДЛАГЫН ТӨРЛҮҮД

Халдлага (Hacking)

Халдлага гэдэг нь мэдээлэл авах, өөрчлөх, устгахын тулд компьютер болон компьютерийн сүлжээнд албан ёсны зөвшөөрөлгүйгээр нэвтрэхийг хэлнэ.

Сүүлийн үед халдлага нь кибер заналхийлэл ба кибер дайны нэг хэсэг болох нь улам бүр ихэсч энэ нь үндэсний аюулгүй байдалд ихээхэн аюул учруулж байна.

<u> Үйлчилгээг бусниулах довтолгоо (Denial-of-Service)</u>

Үйлчилгээг бусниулах довтолгоо гэдэг нь зөвшөөрөлгүй хэрэглэгч өгөгдлийн сан руу нэвтэрч, зөвшөөрөлтэй хэрэглэгчдийг үйлчилгээ авах боломжгүй болгодог.

Хортой код (Malicious code)

Хортой код гэдэг нь системд гэмтэл учруулдаг програмыг хэлдэг. Вирус, өт, Trojan horses зэрэг нь хортой кодын төрлүүд юм.

Компьютерын вирус гэдэг нь компьютерийн системийн хэсэг эсвэл хэрэгцээт файлын хэсэгт өөрийн хувилбарыг үүсгэн олширч, компьютерийн систем болон өгөгдлийг гэмтээдэг хэрэгцээгүй програм юм.

Компьютерын өт нь файлуудыг өөрчилдөггүй боловч хэрэглэгчид харагдахгүйгээр санах ойн хэсэгт сууж, өөрийгөө олшруулснаар үйлдлийн системийн ажиллагааг доголдуулдаг вирусны төрөл.

Trojan horses нь аюулгүй мэт байдаг боловч үнэн хэрэгтээ ил харагдахгүй байгаа програмуудыг зогсоож, системийг халдлагад өртөмхий болгох хортой ажиллагаатай програм.

Хувь хүний мэдээллийг цуглуулж халдлага хийх буюу Social engineering

"Social Engineering" гэдэг нь хууль бусаар мэдээлэл цуглуулж, халдлага хийх арга. Санхүүгийн залилан хийх зорилгоор хувийн мэдээллийг интернэтээр дамжуулан хулгайлах үйлдэл болох фишинг нь үүний жишээ юм. Фишинг нь интернэт дэх ноцтой гэмт хэргийн үйл ажиллагаа болоод байна.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

1. Мэдээллийн аюулгүй байдлын талаар мэдээлэл, мэдлэгтэй байх

Мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах нэг чухал зүйл бол аюулүй байдалд нөлөөлөх аюулын талаар мэдээлэлтэй байж, дүн шинжилгээ хийх явдал юм. Энэ нь мэдээллийн аюулгүй байдалд заналхийлж буй аюулууд, тэдгээрийн өөрчлөлт, хөгжил, шинэ үүсэл зэрэг мэдээллүүдийн талаар хайж, мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийн, аюулгүй байдлын талаарх өөрийн мэдлэгээ цаг үргэлж дээшлүүлж байхыг хэлнэ.

Мэдээлэлд учруулах аюул заналын хандлагыг судалж, дүн шинжилгээ хийн энэ талаарх тайлан мэдээг олон нийтэд түгээгч байгууллагуудыг доор дурдав. Үүнд:

- ✓ <u>http://www.cert.org/cert/</u> CERT
- <u>http://www.symantec.com/business/theme.jsp?themeid=threatreport</u> Symantec <u>http://xforce.iss.net/</u> - IBM
- ✓ <u>http://ncsc.gov.mn/</u> Монголын Кибер аюулгүй байдлын газар
- 2. Мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах

Мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд маш хурдацтайгаар хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн МТ-ийн орчинд зохицох уян хатан, үндэслэл сайтай стратеги, бодлогууд, тохирох аюулгүй байдлын технологийн хэрэглээ, МХХТ-ийн зөв хэрэглээ болон байнгын сонор сэрэмжтэй байхыг шаардаж байна.

Төрийн байгууллагуудыг кибер халдлагаас хамгаалах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Кибер аюулгүй байдлын газар нь Төрийн мэдээлэл, харилцаа холбооны аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд:

- ✓ Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээн дахь кибер халдлага, аюул заналыг илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх
- ✓ Кибер аюулгүй байдлын талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах
- ✓ Төрийн байгууллагуудад кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой эрсдлийн үнэлгээ хийх
- ✓ Кибер аюулгүй байдлын талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах
- ✓ Төрийн байгууллагуудын нэгдсэн, төрийн тусгай холбооны болон ТЕГ-ын нууцлалтай холбооны сүлжээг зохион байгуулах, тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, шинэчлэлтийг хариуцах
- ✓ Төрийн болон төрийн захиргааны байгууллагуудын хооронд төрийн нууц мэдээ, мэдээлэл дамжуулах, солилцох үеийн нууцлал аюулгүй байдлыг хангах гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Цахим орчинд хувийн мэдээллээ хамгаалах энгийн аргууд:

- ✓ Вирусны эсрэг програм болон хамгаалалтын галт ханыг ашиглах.
- ✓ Интернэт кафе мэтийн нийтийн хэрэглээний компьютерийг ашиглахдаа и-мэйл болон бусад хувийн эрхээр ханддаг интернэт үйлчилгээндээ хандсан бол заавал гарч, дараагийн хүнд хэрэглүүлэх.
- ✓ Олон нийтийн сүлжээг зөв, соёлтой ашиглах.
- ✓ Шаардлагагүй бол хувийн мэдээллээ олон нийтийн сүлжээ болон нийтийг хамарсан онлайн уулзалт, семинар, сургалтын үед нээлттэй байлгахаас зайлсхийх.
- ✓ И-мэйл болон бусад цахим хэрэглээндээ хялбар нууц үг сонгохоос зайлсхийх.
- ✓ Онлайн үйлчилгээ авах бол аль болох нэр хүндтэй, албан ёсны байгууллагуудтай хамтран ажиллах.
- ✓ Монголын Кибер аюулгүй байдлын газраас гаргасан зөвлөмжүүдтэй танилцах, хэрэгжүүлэх.

ХЭРЭГЛЭЭНИЙ ПРОГРАМ

Misrosoft Office нь Microsoft Windows болон Apple Mac OS X үйлдлийн системүүдэд зориулсан оффисын програмуудын цуглуулга юм. **Microsoft** корпораци анх 1989 оны 8 сарын 1-нд **Microsoft Office** програм хангамжийг олон нийтэд танилцуулсан. Харин одоо энэхүү програм хангамжийг дэлхий даяар хэдэн тэр бум хүн хэрэглэж байна. Энэ хугацаанд Microsoft Office 2003, Microsoft Office 2007, Microsoft Office 2010, Microsoft Office 2013 гэх мэт уг програм хангамжийн олон хувилбарууд гарсан ба сүүлийн хувилбар нь өмнөх хувилбараа шинэчилж, сайжруулсан байдаг. Хамгийн сүүлийн 15 дахь хувилбар болох MS Office 2013 нь 2012 оны 10 сарын 11-нд гарсан байна. **Microsoft Office** програм хангамж нь дараах програмуудыг агуулдаг. Үүнд:

- ✓ Microsoft Word: Текстэн мэдээлэл боловсруулах програм.
- ✓ Microsoft Word: Хүснэгтэн мэдээлэл боловсруулах програм.
- ✓ Microsoft Power Point: Үзүүлэн, танилцуулга боловсруулах програм.
- ✓ Microsoft Access: Өгөгдлийн сан удирдах програм.
- ✓ Microsoft Outlook: И-мэйл болон хувийн мэдээлэл удирдах програм.
- ✓ Microsoft OneNote: Тэмдэглэл хөтлөх програм.
- ✓ Бусад хэрэглээний програмууд
 - Microsoft Publisher: Хэвлэлийн эх бэлтгэх програм.
 - о **Microsoft Visio:** Диаграм, схем зурах програм гэх мэт.

Бид энэхүү номондоо *Microsoft Office 2010* хувилбарыг авч үзэх ба түүний програмуудын бүрдлээс хамгийн өргөн хэрэглэгддэг *MS Word, Excel, Power Point* програмуудын талаар судална.

MICROSOFT WORD 2010

Microsoft Word нь бичиг, баримт боловсруулахад хэрэглэгддэг програм. Өөрөөр хэлбэл танд электрон баримтыг үүсгэх, засах, хадгалах, форматад оруулах, хэвлэх гэх мэт үйлдэл хийх боломжийг олгодог програм юм.

Бид өмнөх номонд анхан шатны, хамгийн нийтлэг хэрэглэгддэг комдандуудын талаар оруулсан бол энэ удаад дунд шатны мөн л өргөн хэрэглэгддэг чухал командуудыг оруулахыг зорьлоо.

ДЭЛГЭЦИЙН АГШИНГ ABAX /SCREENSHOT/

Ажиллаж буй програмаа орхилгүйгээр, боловсруулж буй баримтаа илүү ойлгомжтой болгох эсвэл илүү мэдээлэл өгөх зорилгоор ямар нэг дэлгэцийн зургийг авч өөрийн оффисын файлд тун хурдан бөгөөд хялбархнаар нэмэх боломжтой. Энэ шинж чанар нь *MS Word, Excel, PowerPoint* болон *Outlook* програмуудад байдаг. Та үүнийг таны компьютер дээр нээлттэй байгаа цонхнуудын аль нэг хэсгийг нь тасалж эсвэл бүтнээр нь зургийг нь авахад хэрэглэж болно.

Дэлгэцийн зургийг баримтад хэрхэн нэмэхийг та дараах даалгавараас харна уу. Үүний тулд эхлээд дурын ямар нэг програмыг ажиллуулж, түүний зургийг баримтад нэмэх болно.

✓ Paint програмыг нээнэ үү. Start цэс рүү орж, All Programs сонгоно. Accessories бүлгийн Paint програмыг сонгож нээнэ.

ſ	🚳 🗌 📮 🦉 🚺 🛨 Untitled - Paint
l	Home View @
	Image Image <td< th=""></td<>

- ✓ Харин одоо **MS Word** програм руу шилжих эсвэл түүнийг эхлүүл.
- ✓ Баримтад дэлгэцийн зургийг / *Paint* програмын зургийг/ байрлуулах байрлалыг сонго.
- ✓ Insert табын Illustration бүлэгт байрлах Screenshot командыг сонго.
- Дүрслэгдэх боломжтой цонхнуудын жагсаалт гарна. Өөрөөр хэлбэл таны компьютер дээр идэвхтэй ажиллаж буй бүх програмуудын жагсаалт гарна. Бидний нөхцөлд **MS Word** болон **Paint** програмуудын цонх гарч ирнэ.



- ✓ Зургийг нь авч оруулахыг хүссэн цонхыг сонгох буюу бид *Paint* цонх дээр дарах үед уг цонхны зураг таны баримтад хуулагдана.
- ✓ Хэрвээ Screenshot товчны доор байрлах суман дээр дарахад гарах Screen Clipping командыг сонговол хулганы заагчийн хэлбэр өөрчлөгдөнө. Та үүний тусламжтай тухайн

цонхыг бүхэлд нь биш хүссэн хэсгийг таслан авч, өөрийн баримтад нэмэх боломжтой. Цонхноос тасалж авахыг хүссэн хэсгийн зүүн дээд буланд заагчийг байрлуулж, шаардлагатай цэг хүртэл баруун доош нь чирж, хулганыг сулласнаар таны хүссэн хэсэг баримтад нэмэгдэнэ. Хэрвээ таны компьютер дээр олон тооны програм ажиллаж буй бол **Screen** *Clipping* командыг дарахаас өмнө зургийг нь авахыг



хүссэн цонх руу нэг удаа шилжих буюу хулганаар нэг дар. Үүний дараа эргэн өөрийн боловсруулж буй баримт руу шилжин **Screen Clipping** командаа дарна.

БАРИМТЫГ ХЭСГҮҮДЭД ХУВААХ

Шинэ баримт нээх үед ямар ч хуваалт хийгдээгүй буюу баримт бүхэлдээ нэг л хэсгээс бүрдэнэ. Та баримтыг хэдэн ч хэсэгт хувааж болох ба хэсэг тус бүрт өөрийн хүссэн форматыг хэрэгжүүлж болно. Жишээ нь та үүнийг ашиглан баримтын зөвхөн нэг хуудсыг олон баганатай, бусад хуудсыг стандарт буюу нэг баганатай байдлаар хийх боломжтой. Та их хэмжээтэй баримтыг олон хэсгүүдэд хувааж, тухайн хэсэг бүрт ялгаатай хөл, толгойн мэдээлэл оруулах буюу эхний хэсгийн толгойн мэдээлэл *Бүлэг 1*, дараагийн хэсгийн толгойн мэдээлэл *Бүлэг 2* гэх мэт байдлаар нэрлэгдэж болох юм. Өөр нэг жишээ бол таны ихэнх баримтыг худасны чиглэл нь portrait буюу босоо чиглэлтэй байдаг. Тэгвэл бид баримтыг хэсгүүдэд хувааснаар тухайн баримтын тодорхой хэсэгт хамаарах хуудаснуудыг landscape буюу хэвтээ чиглэлд тохируулах боломжтой. Үндсэндээ та тухайн хэсэгт хуудасны ирмэгээс авах зай, хуудасны чиглэл, багана, текстийн зэрэгцүүлэлт, хөл, толгойн мэдээлэл, хуудасны дугаар, цаасны хэмжээ гэх мэт олон тохируулгыг бусад хэсгээс нь ялгаатайгаар тохируулах боломжтой болно. Хуваалт үүсгэсний дараа түүнийг өөрчлөх эсвэл устгах нь хялбар байдаг.

Баримтыг хэсгүүдэд хуваах

- ✓ Дурын нэг баримтыг нээж таслахыг хүссэн хэсэгт курсорыг байрлуул.
- ✓ Page Layout табын Page Setup бүлэгт байрлах Breaks командыг сонго.
- ✓ Та баримтад нэмж болох дараах 4 төрлийн section break байдаг болохыг олж харна.
 - Next page: Курсор байрлаж буй байрлалын дараагийн хуудаснаас шинэ хэсгийг эхлүүлнэ.
 - *Continuous*: Курсор байрлаж буй тухайн хуудсанд буюу курсорын байрлалаас хойш дараагийн шинэ хэсэг эхэлнэ.
 - *Even Page*: Курсор байрлаж буй байрлалаас хойш дараагийн тэгш дугаартай хуудаснаас шинэ хэсэг эхэлнэ.
 - Odd page: Курсор байрлаж буй байрлалаас хойш дараагийн сондгой дугаартай хуудаснаас шинэ хэсэг эхэлнэ.

✓ Жагсаалтаас *Next Page* командыг сонгоно уу.



Үүссэн хуваалтыг устгах

- ✓ Section breaks буюу хуваалт хийгдсэн эсэхийг харахын тулд *Home* табын *Paragraph* бүлэг дэх *Show/Hide* товчийг дар.
- E ▼ E ▼ Fr | ≇ ≇ | 2↓ ¶ E = = = | 2= | 2= | 2 ▼ ... ▼ Paragraph 5
- ✓ Дараах байдлаар хуваалтын тэмдэглэгээг харагдана.



✓ Тухайн section breaks дээр курсорыг байрлуулан Delete товчийг дарна.

Тухайн хэсэг дэх текстийг босоо тэнхлэгийн дагуу зэрэгцүүлэлт хийх

Та дээрх байдлаар баримтыг хэд хэд хуваасан бол одоо аль нэг хэсэгт өөрийн хүссэн форматыг тохируулж болно. Өөрөөр хэлбэл та дараах байдлаар ямар нэг форматын тохируулга хийх үед баримтад бүхэлд нь уг формат хэрэгжихгүй, зөвхөн сонгосон хэсэгт л хэрэгжинэ. Ийм байдлаар та баримтын хэсэг тус бүрт ялгаатай форматыг хэрэгжүүлэх боломжтой.

- ✓ Өөрчлөлт оруулахыг хүссэн хэсэгт курсорыг байрлуул.
- ✓ Page Layout табын Page Setup бүлгийн More товч дээр дар.

Page Layout		Reference	es Mailings F
Orientation	Size	Columns	ben Hyphenation ▼
	Page S	Setup	5

✓ Гарч ирэх Page Setup харилцах цонхны Layout табын Vertical Alignment хэсэгт

байрлах доошоо харсан суман дээр дарна. Та Center сонголтыг сонгож, туршиж үзнэ үү. Харилцах цонхны Apply to X3C3FT This section сонгогдсон эсэхийг шалгана уу. This section сонголт нь таны хийж буй өөрчлөлт зөвхөн энэ хэсэгт Л хэрэгжинэ гэдгийг илэрхийлэх тул үүнийг сонгосон эсэхийг анхаарах хэрэгтэй.

✓ Сонголтыг хийсэн бол ОК товчийг дарж, харилцах цонхыг хаана.

Page	
Vertical alignment:	Center 🔽
	Тор
Preview	Justified Bottom
Apply to: This section	Din Line Numbers Borders

✓ Энэ мэт зөвхөн тухайн хэсгийн хувьд дээр дурьдсан хуудасны хэмжээ, дугаар гэх мэт олон форматыг тохируулж болно.

хөл болон толгойн мэдээлэл

Хэсгүүдэд хөл болон толгойн мэдээллийг ялгаатай хэрэгжүүлэх

Заримдаа бидэнд нэг файлд хэд хэдэн ялгаатай хөл, толгойн мэдээлэл оруулах шаардлага гардаг. Жишээ нь, ямар нэг номын файл дээр ажиллаж буй үед номын бүлэг бүрт ялгаатай хөл эсвэл толгойн мэдээллийг оруулах хэрэгтэй болдог. Энэ үед бид эхлээд тухайн файл дээр хуваалт /*secion breaks*/ хийх буюу номын бүлэг бүрийг тасалж, хэсгүүд үүсгэх хэрэгтэй. Үүний дараа дараах зааврын дагуу ялгаатай хөл, толгойн мэдээллийг оруулна.

✓ Ингээд та туршилт хийх файлаа бэлдсэн бол одоо хамгийн эхний хэсгийн толгойн хэсэгт хулганаараа ойрхон 2 товшино уу. Энэ үед Section 1 гэж гарсан байгааг та анзаарсан байх. Энэ бол эхний хэсгийн толгойн мэдээллийг оруулахад бэлэн болсныг илэрхийлнэ.



хэсэг харагдана. Зүүн талд та одоо хэд дэх хэсэгт байгааг хэлэх тухайн хэсгийн тайлбар байгааг харна уу. Баруун талд "*Same as previous*" мессэж дэлгэцэд харагдана. Та олон хэсэгтэй баримтад хөл болон толгойн мэдээллийг нэмэх үед энэ нь дефаултаар баримтад бүхэлд нь хэрэгждэг.



Хоердугаар хэсэгт (болон дараагийн бүх хэсэгт) ялгаатай тулд Header and Footer мөрөн дэх Link to Previous товчийг дар. Энэ үед Same as Previous мессэж харагдахгүй болно. Ингэснээр өмнөх хэсгээс өөр толгойн мэдээлэл орох боломжтой болно гэсэн үг.

	ſ	🖫 Previous
		🗐 Next
Go to Header	Go to Footer	🚆 Link to Previous
	Na	vigation

- ✓ Уг хэсэгт байх толгойн мэдээллийг оруулна уу.
- ✓ Баримтад хэрвээ олон хэсэг байгаа бол дахин *Next* товчийг дарж, дараагийн хэсэгт шилжин *Link to Previous* товчийг дарж, толгойн мэдээллээ оруулах байдлаар цааш үргэлжилнэ.
- ✓ Их биеийн хэсэгт хулганаараа хоёр ойрхон товшсоноор *Header and Footer*-н хэсгийг хаах болно.

✓ Харин одоо та баримтыг бүхэлд нь гүйлгэн харах үед хэсэг бүр ялгаатай толгойн мэдээлэлтэй болсон байгааг харах болно.

Тэмдэглэл: Та хэсэг тус бүрт ялгаатай байдлаар хөлний мэдээлэл оруулахыг хүсвэл дээрх бүх процессыг давтан хийж болно. Хуудасны доор орших хөлний мэдээллийн хэсэгт хулганаараа ойрхон хоёр товшино. Толгойн мэдээллийг үүсгэсэнтэй яг ижил техникийг хэрэглэн үүсгэнэ.

ХҮСНЭГТТЭЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН ЗӨВЛӨГӨӨ

Хүснэгтийн гарчгийн мөрийг хуудас бүрт давтах

Хэрвээ та олон хуудас дамнасан хүснэгттэй ажиллаж буй бол хүснэгтийн гарчгийн мөрийн утгыг хуудас бүр дээр давтан харуулж болно. Үүний тулд дараах алхмуудыг дагана.

✓ Хүснэгтийн хамгийн дээд талын мөрийг буюу гарчгийн мөрийг сонго.

Part Number	Northern	Southern	Eastern	Western
	Region Sales	Region Sales	Region Sales	Region Sales
1001	243		231	654
1002	654	231	223	235
1003	765	432	325	654
1004	23	432	231	234
1005	245	101	432	231

- ✓ *Layout* табын *Data* бүлэг дэх *Repeat Header Rows* товчийг дарна уу.
- ✓ Та хуудсыг гүйлгэн харах үед дараагийн хуудас бүр дэх хүснэгтийн эхний мөрөнд гарчгийн мөрийн утгууд дүрслэгдсэн байна.



